

VIP 76+

2025 ОНЫ
АЖЛЫН ТАЙЛАН

**УХРААГҮЙ,
УРАГШИЛСААР
УРТ ЗАМ ТУУЛЖ
“ПАРЛАМЕНТАД”
ОРЖ ИРЛЭЭ...**

Жуковын

АЛДАРЖАВХЛАН

Монгол Улсын Их Хурлын гишүүн



Монгол Улсын Их Хурал



Монгол Улсын Их Хурлын гишүүн

Жуковын АЛДАРЖАВХЛАН

Харьяалагдаж буй байнгын хороо

- Төсвийн байнгын хорооны гишүүн,
- Эдийн засгийн байнгын хорооны гишүүн,

САНААЧИЛСАН ХУУЛЬ

- Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль
- Цусны донорын тухай хууль
- Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай хууль
- Үндэсний баяр наадмын тухай хууль
- Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль
- Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль
- Хот байгуулалтын тухай хууль
- Монгол Улсын Их Хурлын тухай хууль
- Улс төрийн намын тухай хууль
- Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль

АЖЛЫГ ХЭСЭГ АХАЛСАН

- Ипотекийн зээлийн хөтөлбөрийн хэрэгжилтийг хянан шалгаж, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсэг
- Хот байгуулалтын бодлогын асуудлаар санал, дүгнэлт гаргах, холбогдох хууль тогтоомжийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг
- "Нийслэл Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө" -г УИХ-аар хэлэлцүүлэх ажлын хэсэг

АЖЛЫН ХЭСГИЙН ГИШҮҮН

- 2025 оны төсвийн тухай хуулийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх ажлын хэсэг

ПАРЛАМЕНТЫН БҮЛЭГ

- Монгол-Хорватын парламентын бүлгийн дарга



Дэлгэрэнгүй
мэдээлэлтэй
танилцана уу



alдарjavkhan@parliament.mn



Алдаржавхлан Жуковын



Мэндчилгээ

Нэгэн жарны түүхтэй Хан-Уул дүүргийн хөдөлмөрч иргэд, хүүхэд залуус Та бүхний амрыг айлтгая.

Монгол Улсын түүхэнд анх удаа мэргэжлийн экспертүүдээс бүрдсэн 126 гишүүнтэй, таван намын төлөөлөл бүхий шинэ парламент бүрдсэнээр төлөөллийн зарчим илүү батажсан гэж болно.

Миний бие Хан-Уул дүүргийнхээ иргэдийн итгэл сэтгэлийг өвөрлөн хууль тогтоох төрийн дээд байгууллагад орж ажиллаад 1.5 жилийн хугацааг өнгөрүүлсэн байна. Ингэхдээ УИХ-ын үйл ажиллагааг мэдрэхээс аваад нийгмийн шударга ёсны хүсэмжлэл дээд цэгтээ хүрсэн эгзэгтэй цаг үед хүний эрх, хууль ёс, шударга байдлын зарчмыг хангасан хууль тогтоомжийг батлан гаргах хариуцлагатай үүрэг бий хэмээн ухамсарлаж байна. Тиймдээ ч парламентын гаргасан хууль тогтоомж бүрт улс орны язгуур эрх ашгийг дээдэлсэн, олон тулгуурт гадаад бодлогыг дэмжсэн, нийгэм эдийн засгийн тогтвортой хөгжилд хөтөлсөн, иргэд ААН-ийнхээ эрх ашгийг хамгаалж, сонгогч таны эрх ашгийн үүднээс асуудалд хандаж ажиллалаа. Энэ удаагийн парламент олон хууль тогтоомж гаргасны дотор Хот байгуулалтын тухай хууль, Үндэсний их баяр наадмын тухай хууль, УИХ-ын тухай зэрэг хуулийн төслүүдийг санаачлан батлууллаа.

УИХ-ын гишүүн хууль тогтоохоос гадна сонгогдсон тойргийнхоо нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд гар бие оролцож, шаардлагатай хөрөнгө мөнгийг улсын төсөвт суулгах үүрэгтэй билээ. Хан-Уул дүүрэгт татсан хөрөнгө оруулалтаа харвал чамлахааргүй төсөвт сууж, энэ жил Хан-Уул дүүрэгт бүтээн байгуулалтын жил байна гэдгийг та бүхэнд дуулгахад таатай байна. Тухайлбал, манай дүүрэгт 2025 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар

7 сургууль, 4 цэцэрлэг шинээр ашиглалтад орсон бол нэмээд 2026 онд улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр шинээр 15 сургууль, 8 цэцэрлэг, 3 бага сургууль цэцэрлэгийн цогцолбор, 14 байршилд 23.7 км хатуу хучилттай авто зам, 5 байршилд 4.6 км инженерийн дэд бүтэц шинээр баригдахаар төлөвлөгдөж байна. Энэ жил Хан-Уулчуудын хувьд том бүтээн байгуулалтын жил хэмээн тодотгохоос гадна миний хувьд “Хамгийн сайн сургууль гэртээ ойр сургууль гэж би хувьдаа боддог. Тийм ч учраас боловсролын салбарт түлхүү анхаарч, хүүхэд багачууд маань айх аюулгүй гэрийнхээ ойр сургууль, цэцэрлэгтээ явах боломж нөхцөл бүрдэж байгаад хувийн зүгээс онцгой анхаарч ирсэн. Цаашдаа ч анхаарч, эхлүүлсэн ажлууд маань үр дүнгээ өгч эхнээсээ хэрэгжиж байгаад баяртай байна. Мэдээж бүхнийг шийдвэрлэж амжаагүй. Хүсэл байв ч төсвийн хэмжээ, цаг хугацааны хязгаар хоёрт бүгд захирагдаж явдгийг Та бүхэн юу эс андах билээ. Гэлээ ч эхлүүлсэн ажлаа дуусгаж, эргэх холбоотой иргэдийнхээ асуудал, бэрхшээлийг шат шатанд шуурхай шийдвэрлэх нөхцөлийг бүрдүүлэх, та бүхний өдөр тутмын аж амьдралд ойр хуулийг санаачлан хэрэгжүүлнэ гэдгээ дахин та бүхэнд дуулгая.

Ингээд та бүхэндээ 2024-2025 оны хугацаанд хийж хэрэгжүүлсэн ажлынхаа тухай эргэцүүлж, хийсэн ажлуудаа танилцуулах үүднээс товч “тайлан” сэтгүүлээ эмхэтгэн хүргүүлж байна.

Та бүхэн айлчлан ирж буй XVII жарны Сүрээр дарагч хэмээх гал Морин жилдээ эрүүл энх, аз жаргалтай, хийж бүтээхийн тэмүүлэл дүүрэн байхыг хүсэн ерөөе!

Хүндэтгэсэн:

Улсын Их Хурлын гишүүн,
УИХ дахь МАН-ын бүлгийн Дэд дарга
Жуковын **АЛДАРЖАВХЛАН**



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ 2024-2025



■ УИХ-ын бүтэц, үйл ажиллагаанд орсон онцлох өөрчлөлтүүд:


• УИХ-ын хуралдааны дэгийн тухай хуульд орсон өөрчлөлтүүдийн хүрээнд “Ерөнхий сайдын мэдээллийн цаг”-ийг “УИХ-ын гишүүдийн асуулгын цаг” болгон өөрчилж, мэтгэлцээний зарчмаар явуулдаг болов.

• Байнгын хороодын бүтцэд өөрчлөлт оруулан зарим хороодыг нэгтгэж, Өргөдлийн байнгын хороог шинээр байгуулав.

• Намрын ээлжит чуулган эхлэх хугацааг 9 дүгээр сарын 15-ны өдөр болгон наашлуулж, төсвийн төслийг хэлэлцэх хэлэлцүүлгийн үе шатыг 4 байсныг 5 үе шаттай болгож нэмэгдүүлэв.

УИХ-ЫН НАМРЫН ЧУУЛГАНЫ ХУГАЦААНД

Эдийн засгийн байнгын хороо



Төсвийн байнгын хороо




Монгол Ардын намын бүлэг






ХАМГИЙН ОЛОН ХУУЛЬ САНААЧИЛСАН УИХ-ЫН ГИШҮҮД



2025 ОНЫ НАМРЫН ЧУУЛГАНЫ ИРЦ





**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРАЛ**

126 ГИШҮҮНТЭЙ АНХНЫ ПАРЛАМЕНТ

САНААЧИЛСАН ХУУЛИУД

- Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль
- Цусны донорын тухай хууль
- Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай хууль
- Үндэсний баяр наадмын тухай хууль
- Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль
- Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль
- Хот байгуулалтын тухай хууль
- Монгол Улсын Их Хурлын тухай хууль
- Улс төрийн намын тухай хууль
- Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль

ДЭГИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙГ ӨРГӨН БАРИВ

Миний бие УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг М.Бадамсүрэн нарын 33 гишүүний хамтаар санаачлан, боловсруулж УИХ-д өргөн мэдүүллээ.

Үндсэн хуульд заасны дагуу Улсын Их Хурал өөрийн бүрэн эрхийн хүрээнд аливаа асуудлыг хэлэлцэхдээ хуралдааны дэгийг өөрөө тогтоох эрхтэй. Гэвч Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулиар санал хураалт явуулах ерөнхий журмыг нарийвчлан зохицуулаагүйн улмаас үр дүн муутай томьёоллоор санал хураалтыг явуулж буй нь УИХ-ын бүрэн эрх, холбогдох бусад хуулийн зарчимд нийцэхгүй байна хэмээн үзэж хуулийн төслийг санаачлан боловсрууллаа. ■



Хуульд орж байгаа онцлох өөрчлөлт:

- Ерөнхий сайдыг огцруулах асуудлыг хэлэлцэх, Ерөнхий сайдад тодорхой асуудлаар итгэл хүлээлгэх эсэх асуудлыг хэлэлцэх дэгд УИХ уг асуудлыг 7 хоногийн дараа хэлэлцэж эхлэн 10 хоногийн дотор шийдвэрлэхээр заасныг Үндсэн хуулийн холбогдох заалттай нийцүүлж 3 хоногийн дараа хэлэлцэж эхлэн 10 хоногийн дотор шийдвэрлэхээр өөрчлөх.
- Ерөнхий сайд бүрэн эрхийнхээ хүрээнд ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮНИЙГ ТОМИЛОХ, ЧӨЛӨӨЛӨХ асуудлыг тав хоногийн дотор УИХ-ын нэгдсэн чуулганы хуралдаанаар сонсохоор тусгав.
- УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанд мэргэжлийн Байнгын хорооны хуралдаанаас гаргасан зөвхөн дэмжсэн саналыг дэмжжээ гэсэн томьёоллоор санал хураах буюу Байнгын хорооны хуралдаанд оролцсон нийт гишүүд дэмжсэн, дэмжээгүйгээс үл хамаарч эрх бүхий этгээдийн анх гаргасан саналыг нь дэмжих эсэхээр санал хураах гэсэн гол өөрчлөлтүүдийг оруулсан. ■

БАЙНГЫН ХОРООДЫГ НЭГТГЭН БҮТЦИЙГ ЦОМХОН, ЗОХИСТОЙ БОЛГОВ



УИХ-ын 11 Байнгын хороо хуульд заасан эрхлэх асуудлынхаа хүрээнд УИХ-д өргөн мэдүүлсэн хууль тогтоомжийн төслийн талаар санал, дүгнэлт гаргах, нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх, УИХ-ын хяналт шалгалтыг хэрэгжүүлэх бүрэн эрхтэй.

Харин байнгын хороодын тоо олон байгаагаас үүдэн хэлэлцэх асуудал харилцан адилгүй, ажлын ачаалал өөр өөр байна. Түүнчлэн, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэгт Байнгын хороо 25 хүртэл гишүүний бүрэлдэхүүнтэй байхаар заасан ч өргөн мэдүүлсэн хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэн санал дүгнэлт гаргах, УИХ-ын хяналтыг хэрэгжүүлэх чиг үүрэгтэй зарим Байнгын хороо 11-12 гишүүний бүрэлдэхүүнтэй буюу хуульд заасан тооны дээд хязгаар 50%-д ч хүрэхээргүй байсан!

Иймд УИХ-ын зохион байгуулалтыг цомхон, үйл ажиллагааг боловсронгуй болгон сайжруулах, бодлогын шийдвэрийг илүү мэргэшсэн байдлаар хэлэлцэн, уялдаа холбоотой, нэгдмэл гаргах, Байнгын хороодод харьяалагдах гишүүдийн тоог нэмэгдүүлэх хүрээнд зарим Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээг нэгтгэх, эрхлэх асуудлын тодорхой хэсгийг дэд хороонд харьяалуулах нь зүйтэй. ■

Хууль батлагдсанаар:

- УИХ-ын Байнгын хороодыг нэгтгэн бүтцийг цомхон, зүй зохистой болгоно;
- Байнгын хороодод харьяалагдах гишүүдийн тоог нэмэгдүүлэн, эрхлэх асуудлыг оновчтой хуваарилж ажлын ачааллыг тэнцвэржүүлнэ;
- Дэд хороод байгуулан бодлогын асуудлыг илүү мэргэшсэн байдлаар хэлэлцэн, харилцан уялдаатай, нэгдмэл шийдвэр гаргах боломж бүрдлээ;



УИХ-ын гишүүн П.Сайнзориг:

Маш чухал хуулийн төсөл орж ирж байна. Энэ хуулиар байнгын хороодын тоог цөөрүүлбэл бид нар бүтээмж болон хурд, УИХ-аас хэлэлцэн баталж байгаа бодлогын уялдаанууд хангагдана гэж харж байна. ■

Улс төрийн намын тухай хууль
Өргөн барьсан 2025.09.26

НАМУУДЫН ОРЛОГЫН ХЭМЖЭЭНД ХЯЗГААРЛАЛТ ТОГТООЖ БАЙГААГ ӨӨРЧИЛНӨ

Улс төрийн намын тухай хуулийг 2024.01.01-ний өдрөөс дагаж, мөрдөж эхэлсэн. Улс төрийн нам БАНКНЫ ЗӨВХӨН НЭГ ДАНСТАЙ байхаар зохицуулснаас үүдэн намын шат шатны байгууллагын үйл ажиллагаа санхүүгийн төлбөр тооцоо, мөнгөн гүйлгээтэй холбоотойгоор зогсонги байдалд орох, хугацаа алдах зэргээр хүндрэл үүссэн. Энэ нь улс төрийн намын орлогын эх үүсвэр, зарцуулалт ил тод, нээлттэй байх хуульд заасан шаардлага хангагдах боломжгүйд хүргэж, иргэдийн улс төрийн намын үйл ажиллагаанд оролцох эрхийг бодитой эдлүүлэх эрх зүйн баталгаа хангагдахгүй байгаа юм. ■



Яагаад өөрчлөгдөх шаардлагатай вэ?

- УИХ-д суудал бүхий улс төрийн намуудад санхүүжилт олгох, санхүүжилтийн хэмжээнээс хамаарч намын бусад орлогын хэмжээнд хязгаарлалт тогтоож байгаа нь намын үйл ажиллагаа тогтвортой явуулах, санхүүгийн хувьд дотооддоо бэхжих боломжийг хааж байна!
- Намын дэргэдэх байгууллагуудын санхүүгийн тайланг нэгтгэх, харьяа байгууллагуудын санхүүгийн мэдээллийг тусгахаар хуульчилсан нь нам санхүүгийн тайлагналын хувьд олон дамжлага дамжихын зэрэгцээ хуульд заасан санхүүжилтийн дээд хэмжээ зөрчигдөхөд хүргэж байна!

Хуулийн төслийн зорилго:


- Үндсэн хуульд заасан иргэдийн эвлэлдэн нэгдэх, улс төрийн намын үйл ажиллагаанд оролцох, эс оролцох эрх хангагдана.



УИХ-ын гишүүн Ж.Алдаржавхлан:

Хуулийн төсөл батлагдсанаар УИХ-аас батлагдсан Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулга бодитойгоор хэрэгжих боломжтой болохын зэрэгцээ Улс төрийн намын аймаг, нийслэл, сум, дүүргийн анхан шатны нэгж санхүүгийн хувьд нээлттэй, ил тод байх зарчмыг хангах, шат шатны намын байгууллагуудын үйл ажиллагаа тогтвортой хэвийн явагдах эрх зүйн үндэслэл бүрдэнэ. ■

ЦУСАА ХАНДИВЛАХ ҮЙЛ ЯВЦ ЭРСДЭЛГҮЙ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН БОЛОВСРОНГУЙ БОЛНО



Монгол Улс Донорын тухай хуулиар цусны болон эд эс эрхтний донорын асуудлыг зохицуулж байв. Олон нийтэд цусаа өгөхийг уриалах боломжтой ч эд, эс эрхтний донор болохыг ухуулах нь хүнд сэдэв тул хоёр тусдаа хуулиар зохицуулах шаардлага үүссэн юм. Мөн манай улсын хүн ам өсөн нэмэгдэхтэй зэрэгцэн цусны хэрэглээ нэмэгдэж, ялангуяа хөдөө орон нутагт цусны нөөц асар дутагдалтай байгаа нь, Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр “Цусны төв”-ийг сайжруулж, халдварт өвчин тархаахгүйгээр ажиллах нөхцөл бүрдсэн нь эрх зүйн зохицуулалтыг шинэчлэн сайжруулах үндэс болсон юм. ■

Монгол Улсад **170** мянган цусны донор бий. Тэд 1 удаа цус өгөхөд **500** мянган хүний эрүүл мэнд, амь насыг аварч, амьдрал бэлэглэдэг.



Цусны донорын тухай хууль батлагдсанаар:

- Цусны донорын сургалт, сурталчилгаа сайжирч, орон нутагт ахиц дэвшил гарна;
- Цусны донорын нийгмийн халамж, урамшуулал сайжирч, тоо нь нэмэгдэх боломжтой;
- Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын үед цус, цусан бүтээгдэхүүний нөөц, хангамж бүрэн шийдэгдэнэ;


УИХ-ын гишүүн Ж.Алдаржавхлан:

Цусны донорын тухай хуулийн төслийг найман бүлэг, 35 зүйлтэйгээр боловсруулсан бөгөөд хууль батлагдсанаар цус сэлбэлт судлалын салбарын эрх зүйн орчин боловсронгуй болж, цаашид хөгжин дэвших шинэ боломжууд нээгдэх, иргэд эх орондоо дэлхийн жишигт нийцсэн чанартай тусламж, үйлчилгээг хүртээмжтэй хүртэх, цусны донорын сургалт, сурталчилгаа, орон нутаг дахь үйл ажиллагаанд ахиц дэвшил гарах, эмнэлгийн мэргэжилтэнд тавигдах шаардлага тэдний эрх үүрэг тодорхой болох, донорын нийгмийн халамж, алдаршуулах, урамшуулах явдал сайжирч, тэдний тоо нэмэгдэх зэрэг эерэг үр дүн гарна. ■



Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай хууль
Өргөн барьсан 2025.03.31

ЭД, ЭРХТНЭЭ ШИЛЖҮҮЛЭХ ЭМЗЭГ, МАРГААНТАЙ АСУУДЛУУДАД ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ ХИЙНЭ



Эд, эс, үр шилжүүлэн суулгах эмчилгээний төрлүүд маш хурдацтай хөгжиж байна. Анагаах ухааны гайхамшигтай үр дүнгүүд иргэдийн амьдралын чанарыг сайжруулах, үр хүүхэдтэй болох, амьдруулах зэргээр хүсэл мөрөөдлийг нь биелүүлдэг болжээ. Ийм учраас цаг үеийн шаардлагаар Эрхтэн, эд эс шилжүүлэн суулгах тухай хуулийн төслийг УИХ-ын гишүүн Ж.Чинбүрэн нарын гишүүдийн хамтаар өргөн мэдүүллээ. ■



- Монгол Улс анх 2006 онд бөөр шилжүүлэн суулгаснаар эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах эмчилгээ эхэлсэн.
- Үүнээс хойш 2011 онд элэг, 2014 онд ясны чөмөг, үүдэл эс, 2018 онд элэг шилжүүлэн суулгах баг тус тус байгуулагдаж шилжүүлэн суулгах эмчилгээг хийж байна.

Хуулийн төслийн онцлох өөрчлөлтүүд:


- Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах эмчилгээний эрх зүйн орчин улам боловсронгуй болж, эмчилгээний аргууд улам нэмэгдэж, хөгжин дэвших шинэ боломжууд нээгдэнэ.
- Нийгмийн даатгал төлдөг, эс төлдөг эсэхийг үл хамааран тайтгарлын зардал өгөхөөр тусгасан. Амьгүй донорын гэр бүлд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин нэмэгдүүлэн олгох тэтгэмж бол оршуулгын зардлын хэмжээг тооцсон мөнгөн дүн юм.
- Мөн иргэд эх орондоо дэлхийн жишигт нийцсэн чанартай эмчилгээ үйлчилгээг хүртээмжтэй хүртэх, гадаад улс орон руу эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах эмчилгээнд явах зардал, чирэгдэл мэдэгдэхүйц багасаж, гадагшаа урсах мөнгөний урсгал буурна.
- Түүнээс гадна эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах үйл ажиллагааг зохицуулах удирдлагын тогтолцоо, үйл ажиллагаа шинэ шатанд гарах, эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах эмчилгээ үйлчилгээний шаардлагатай багаж хэрэглэл, тоног төхөөрөмж, шинжилгээ судалгаа, сургалтын үйл ажиллагааны санхүүжилтийн шинэ тогтолцоо бий болон хөгжинө.
- Монгол Улсад хөдөлмөр эрхлэх гадаад ажилтны тоо, хувь хэмжээ тогтоохгүй байх, ажлын байрны төлбөрөөс чөлөөлөх тухай



УИХ-ын гишүүн Ж.Чинбүрэн:

Амьд донорын аюулгүй байдал хамгийн чухал асуудал. Бид энэ талаар судалсан. Гэхдээ аль болох амьд донороос эрхтэн шилжүүлэхгүй байх тогтолцоог бүрдүүлэхийг зорьж байна. Манайд амьгүй донор олдохгүй учраас хайртай дотнын хүнийхээ амь насыг аврах гэж иргэний эр зориг гаргаж эд, эрхтнээ шилжүүлэн өгч байна. Мэргэжилтнүүд донор болох хүнд сэтгэл зүйн тестүүдийг хийх, донор болох гэрээслэл үлдээх зэрэг маргаантай асуудлуудад эрх зүйн зохицуулалт хийхийг зорьсон. ■

ҮНДЭСНИЙ НЭГДМЭЛ “ҮНЭТ ЗҮЙЛ”-ИЙГ ТӨЛӨВШҮҮЛЭВ



Миний бие Б.Жаргалан нарын 40 гишүүний хамтаар Үндэсний их баяр наадмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг санаачлан, өргөн барьсан. Улмаар /2025.07.03/-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар эцэслэн батлагдаж, тус өдрөөс хууль хэрэгжиж эхлээд байна.

Энэ хуулийн өөрчлөлтөөр Тулгар төр байгуулагдсаны ой, Их Монгол Улс байгуулагдсаны ой, үндэсний тусгаар тогтнолоо сэргээн тогтоосон Үндэсний эрх чөлөөний хувьсгал, Ардын хувьсгал, Ардчилсан хувьсгалын ойн баярыг улсын баяр наадамтай хамтатган тэмдэглэх зохицуулалтыг Үндэсний их баяр наадмын тухай хуульд тусгалаа. ■



УИХ-ын гишүүн Ж.Алдаржавхлан:

Монгол Улсын Үндсэн хуулийн оршил хэсэгт төрт ёс, түүх, соёлынхоо уламжлалыг нандигнан өвлөж, эх орондоо иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийн эрхэм зорилгоо болгосон байдаг учир Үндэсний их баяр наадмаа тэмдэглэхдээ эдгээр үйл явдлыг санан дурсаж, ухамсраа сэргээж байх нь зүй ёсны хэрэг юм. ■

Хууль батлагдсанаар:

Их Монгол Улс байгуулагдсаны ой, Ардын хувьсгалын ойн баяр наадамтай хамт Тулгар төр байгуулагдсаны ой, үндэсний тусгаар тогтнолоо сэргээн тогтоосон Үндэсний эрх чөлөөний хувьсгалын ой, Ардчилсан хувьсгалын ойг Үндэсний их баяр наадмын тухай хуульд албан ёсоор заах нь Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, үндэсний эв нэгдэл, төрт ёс, түүх, соёл, өв уламжлал, зан заншлыг бэлгэдсэн үндэсний уламжлалт баяр болох Үндэсний их баяр наадмыг агуулгыг бүрэн илэрхийлж, үндэсний нэгдмэл үнэт зүйлийг төлөвшүүлэх боломж бүрдлээ. ■

Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль
Өргөн барьсан 2025.07.04



БИОКОМБИНАТ, ШУВУУН ФАБРИК ОРЧМЫН ГОЛЫН САВ ДАГУУ ХАЙРГА, ДАЙРГА ОЛБОРЛОХЫГ ХОРИГЛОНО

УБ хотын барилга, авто замын бүтээн байгуулалтад ашиглагдаж буй хайрга, дайргыг 100 хувь нийслэлийн нутаг дэвсгэрээс олборлож байгаа. Тодруулбал, Туул голын сав газраас хайргыг ихээр олборлож байгаа нь нийслэлийн иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг ноцтой зөрчиж байгаа юм. ■

Яагаад өөрчлөгдөх шаардлагатай вэ?

- Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.3 болон 17 дугаар зүйлийн 17.4 дэх хэсэгт 2021 оны нэмэлт оруулж Суурьшлын болон ногоон бүсээс 1 км дотор түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгохыг хориглохоор хуульчилсан боловч усны сан бүхий газар, түүний хамгаалалтын бүсэд түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олгохтой холбоотой харилцааг зохицуулаагүй!

- Аймаг, нийслэлийн ИТХ нь газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын болон уурхайн талбайг тусгах эрхтэй боловч, ашиглалтын үйл ажиллагаа явуулсны дараа байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд үндэслэн цаашид хайгуулын болон олборлох үйл ажиллагаа явуулах эсэхийг шийдвэрлэх бүрэн эрхийг нарийвчлан тодорхой хуульчлаагүй!



Хуулийн төслийн зорилго

- Цаашдаа усан сан бүхий газарт түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, олборлох, ашиглах зөвшөөрөл олгохгүй байх;
- Одоо үйл ажиллагаа явуулж байгаа ААН-үүдийн үйл ажиллагааг үе шаттай зогсоох;
- Энэ чиглэлээрх эрх зүйн орчныг эргэн харах;



“
Хууль батлагдсанаар
Биокомбинат, шувуун
фабрик орчмын голын ай
сав дагуу зөвшөөрөлтэй
болон зөвшөөрөлгүй хайрга
дайрга олборлолтыг
хуулиар хориглоно. Мөн
гадна нөхөн сэргээлт
хийгдэж, иргэдийн амьдрах
орчны аюулгүй байдал
хангагдана.



УИХ-ын гишүүн Ж.Алдаржавхлан:

Туул голын баруун талын бүх бургасыг ХЯДАЖ хайрга олборлоод ОНГОРХОЙ НҮХ болгоод хаячихсан. Хайрга олборлосон нөхдүүд ухчаад хаяад явчихдаг байх жишээний. Шувуун Фабрик, Өлзийт хороолол, Биокомбинатад энэ мэт олон нүхнүүд байгаа. Дараа нь эзэд нь олддоггүйн дээр хуулийн ямар ч хариуцлага байдаггүй! Миний хувьд энэ хуулийг санаачлахдаа, нэгдүгээрт, голын эрэг дагуу хайрга олборлохыг зогсооё. Байгалиа сүйтгэхээ больё. Хоёрдугаарт, өмнө нь олборлоод хаяад явчихсан нөхдүүдтэй хариуцлага тооцъё

Юу өөрчлөгдөж байна вэ?

- Усны сан бүхий газарт түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олгохгүй байх эрх зүйн орчныг бүрдүүлэх;
- Олгогдсон тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаанд байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийлгэх үндэслэл, байгаль орчинд сөрөг нөлөөлөл үзүүлж буй дүгнэлт гарсан тохиолдолд тусгай зөвшөөрлийг цуцлахтай холбоотой харилцааг нарийвчлан, тодорхой зохицуулах;

гэж байгаа юм. Энэ хүрээндээ Зөрчлийн хуульд шинэ заалт оруулж, эргэж нөхөн сэргээлгэх ажлыг хийх хуулийн заалттай өргөн барьсан. Уг хуулийн төсөл нь Нисэх, Яармаг, Туул гол орчимд амьдарч буй иргэдэд нэн чухал хууль. Өмнө нь ямар ч гишүүн уг хуулийг санаачилж байгаагүй юм билээ. Миний хувьд гишүүн болсон цагаасаа л энэ хуулийг санаачлахад Байгаль орчны яам болон бусад байгууллагуудтай хамтарч ажилласны дүнд УИХ-д Засгийн газрын дэмжлэгээр ийн өргөн барилаа. ■

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль
Өргөн барьсан 2025.07.08

ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИД ИЖИЛ, ТЭГШ ЭРХ ЗҮЙН ОРЧИНД АЖИЛЛАХ БОЛОМЖ БҮРДЭНЭ




Миний бие УИХ-ын гишүүн ХОТгонбаяр нарын гишүүдийн хамтаар хуулийн төслийг өргөн барилаа.

Хуулийн төсөлд өөрчлөлт орсноор:

- “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх зарчим хангагдах,
- Шат шатны иргэдийн Төлөөлөгч нар ижил тэгш эрх зүйн орчинд ажиллах боломж бүрдэх,
- Хуулиар эрх зүйн ялгаатай байдал үүсгэж байсан хуулийн хийдлийг арилгах зэрэг олон талын ач холбогдолтой.

Хуульд орох гол өөрчлөлт:

- 38 дугаар зүйлийн 38.6 дахь хэсэгт “Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчдийн гуравны нэг хүртэлх хувь нь төрийн захиргааны албан хаагч байж болно” гэж заасныг
- “Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчдийн 50% нь төрийн захиргааны албан хаагч байж болно” гэж хамрах хүрээг өргөжүүлж, хувь хэмжээг нэмэгдүүлэв.



Түүнчлэн Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахтай холбогдон дагалдах хуулиудад өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг УИХ-ын гишүүн О.Амгаланбаатар нарын гишүүдийн хамтаар өргөн мэдүүлээ.

Уг хуульд төрийн чиг үүргийг хэрэгжүүлэх агентлагуудын орон нутаг дахь байгууллагын захирал, удирдлагуудыг томилох, чөлөөлөх эрхийг хуулиар Засаг даргад олгох асуудлыг тусгав. ■



ШИНЭЭР ХОТХОН, ХОРООЛОЛ БАРИХ БОЛ “ЗААВАЛ” УЛСЫН СУРГУУЛЬ, ЦЭЦЭРЛЭГТЭЙ БАРИНА

Хотжих үйл явц эрчимжиж, хот, суурин газрыг чиглэсэн хүн амын шилжилт хөдөлгөөний нөлөөгөөр томоохон хот, суурин газарт хүн ам, үйлдвэрлэл, үйлчилгээний төвлөрөл үүсэж, дэд бүтэц, боловсрол, эрүүл мэнд зэрэг иргэдэд зориулсан төрийн үйлчилгээний хүртээмж муудаж, түүнээс шалтгаалсан эдийн засаг, нийгмийн тулгамдсан асуудлууд үүсэх болсон.

Иймд Хот байгуулалтын тухай хуульд нэмэлт оруулж, хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд тавигдах шаардлагад эмнэлэг, сургууль, цэцэрлэг, тэдгээрийн хүртээмжийг тооцоолсон байхаар, түүнчлэн хот, тосгоныг хөгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө нь **“250 хүртэлх өрх тутамд нэгээс доошгүй цэцэрлэг, 1000 хүртэлх өрх тутамд нэгээс доошгүй төрийн өмчит сургууль”**-ийг төлөвлөх шаардлага үүссэн билээ.

Энэ хүрээнд анх гишүүний тангаргаа өргөж, парламентын чуулганы үеэр хэлсэн миний анхны үг “1000 хүртэлх хүн амтай хотхон, хороолол барихаар бол заавал УЛСЫН СУРГУУЛЬ, ЦЭЦЭРЛЭГТЭЙ БАРИХ хуулийн төслийг боловсруулж, шинэчлэн батлуулна” гэж хэлж байлаа. Улмаар 2024 оны намраас хойш Хот байгуулалтын тухай хуулийн төсөл дээр ажиллаж /2025.05.02/-ны өдөр УИХ-д өргөн барьж улмаар /2025.07.09/-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар эцэслэн БАТЛАГДЛАА. ■





Хот байгуулалтын тухай хуулиар зохицуулсан харилцаа:

250
1000


хүртэлх өрх
тугамд
хүртэлх өрх
тугамд

>

НЭГЭЭС ДООШГҮЙ ЦЭЦЭРЛЭГ

>

НЭГЭЭС ДООШГҮЙ ТӨРИЙН ӨМЧИТ СУРГУУЛЬ



Хот, тосгоны хөгжлийн төлөвлөгөөнд:

- Эмнэлэг, сургууль, цэцэрлэгийн хүртээмжийг тооцно.

Аймаг, Нийслэлийн засаг дарга

- Хот, тосгоны ерөнхий төлөвлөгөөг боловсруулах, шинэчлэх санаачилга гаргана.

Аймаг, Нийслэлийн засаг дарга

- ✓ Газар олгох
- ✓ Хэрэгжилтийг зохион байгуулах
- ✓ Хяналт тавих, тайлагнах үүрэг хүлээнэ.

Аймаг, Нийслэлийн ИТХ

- Төв байгууллагын саналыг үндэслэн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг батална.



**УИХ-ын гишүүн
Ж.Алдаржавхлан:**

Иргэдэд хамгийн их тулгамдсан нэг ч гэсэн асуудал шийдвэрлэгдэж, өргөн барьсан хууль маань батлагдсанд баяртай байна.

Хуулийн ач холбогдол:

Хот, суурин газарт эмнэлэг, сургууль, цэцэрлэгийн хүртээмжийг оновчтой тооцож, хуульд заасан өрхийн тоо хэмжээг харгалзан төлөвлөлтийн баримт бичигт тусгах, улмаар уг төлөвлөлтөд тавигдсан шаардлагыг баримтлаагүй бол барилгын ажлыг эрхлэх зөвшөөрлийг олгохгүй байхаар хуульчилсан. Мөн энэ талаарх аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын эрх, үүргийг тодорхой болгосон. ■

ИРГЭН ТА

“8 НЭРИЙН ДЭЛГҮҮР, ДУГУЙ ЗАСВАР, ОЁДЛЫН ЦЕХ, ҮСЧИН НЭЭЛЭЭ”

ГЭЖ МЭДЭГДЭХЭД Л БОЛНО


Иргэд найман нэрийн дэлгүүр ажиллуулахын тулд олон сараар зөвшөөрөл хүлээгээд суух ёсгүй. Үсчин ажиллуулахын тулд “тамга дутуу” гэх шалтгаанаар төрийн үүд сахиад явах нь утгагүй. Залуучууд кофе шоп нээе гээд зөвшөөрөл хүлээсээр үйл ажиллагаа нь эхлэхээсээ өмнө дампуурдаг байж хэрхэвч болохгүй! Иймд авлигыг тэтгэдэг хүнд суртлын хөрсийг хуулж, иргэний эдийн засгийн эрх, эрх чөлөөг хамгаалан, хийж бүтээх хүслийг нь дэмжих зорилгоор Зөвшөөрлийн тухай хуулийг УИХ-ын дарга Н.Учрал нарын гишүүдийн хамтаар санаачилж, өргөн барилаа.



Өөрийн гараар амьдралаа өөд нь татъя, ашиг орлого олъё гэсэн хүний хүслийг хяссан ЗӨВШӨӨРӨЛ нэртэй ХОРИГЛОЛТЫН системээс чөлөөлөх нь энэ хуулийн эрхэм зорилго, үзэл санаа гэдгийг тодотгох нь зүйтэй.

2022 онд Зөвшөөрлийн тухай хууль шинэчлэн батлагдаж 1000 гаруй зөвшөөрлийг 381 болгож цөөлсөн. Гэвч гэрчилгээ, бүртгэл, тохирол, лавлагаа, тодорхойлолт гэх мэт нэр, зүсийг нь өөрчилж, хувиргасан хүнд суртлын тогтолцоо ахин дахин амилах санаархлыг үндсээр нь зогсоох хэрэгцээ шаардлага үүссэн юм. ■

Иргэн таныг ЗӨВШӨӨРӨЛ нэртэй хориглолт, хүнд суртлын цааснаас хэрхэн чөлөөлөх вэ?



1. Зарим салбарт нэг төрлийн үйл ажиллагаа эрхлэхийн тулд олон зөвшөөрөл авах хэрэггүй болно. Жишээ нь, барилгын салбарт 16 давхар байшин босгохын тулд 3 төрлийн тусгай зөвшөөрөл хөөцөлдөж, 3-4 жил хүлээхгүй. Нэг үйл ажиллагаанд нэг л төрлийн зөвшөөрлийг 22 өдөрт багтаан авна.
2. Зөвшөөрлөө сунгуулахад 20 хоног магадлуулан шалгуулдаг. Зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг зөрчөөгүй нь тогтоогдсон бол ажлын 2 өдөрт шууд сунгана.
3. Энгийн 120 зөвшөөрөл олгох, 30 мэдэгдэл бүртгэх эрх салбарын мэргэжлийн нэгдсэн холбоонд шилжинэ. Төрийн яам тамгын газрын ажлыг хүлээн зөвшөөрөгдсөн холбоод гүйцэтгэнэ.
4. Тусгай зөвшөөрлийн хугацаа 5 жил байгааг 10 жил болгоно. Энгийн зөвшөөрөл 3 жилээс 5 жил болно.
5. Мэдэгдлээ илгээгээд 30 хоногт хариу аваагүй байсан зөвшөөрөл олгогдсонд тооцно.
6. Тусгай зөвшөөрөл шаарддаг 32 төрлийн үйл ажиллагааг энгийн зөвшөөрөлд шилжүүлнэ. Энгийн зөвшөөрөл хүссэн хариуг 30 хоногт өгөөгүй бол шууд олгосонд тооцно.
7. Төрөөс олгодог 20 зөвшөөрөл нь хуулиар хүчингүй, хэрэгцээ шаардлагагүй болно.
8. Засгийн Газрын Хэрэг эрхлэх газар бус Эдийн засаг, хөгжлийн яам эрхэлнэ. Эдийн засаг, хөгжил, бизнесийн орчноо хариуцсан яам хариуцна.



УИХ-ын гишүүн Ж.Алдаржавхлан:

Зөвшөөрлийн тухай хуулийн шинэчлэлтээр тусгай зөвшөөрөл олголтыг хариуцлагажуулж, хяналттай болгох хэрэгтэй. Тухайлбал, усны үйлчилгээг зохицуулах хороо, эрчим хүчний зохицуулах хороо мэтийн тусгай зөвшөөрөл олгодог ч араас нь хяналт тавьдаггүй байгууллагуудын асуудлыг уг хуулиар зохицуулах шаардлагатай! ■

ИПОТЕКИЙН ЗЭЭЛ НЬ ХӨРӨНГӨЖСӨН ХЭСГИЙН ХӨРӨНГӨӨ ӨСГӨХ “ХЭРЭГСЭЛ” БАЙХ УЧИРГҮЙ!



МОНГОЛ УЛСЫН ИК ХУРАЛ

Ипотекийн зээлийн хөтөлбөр хэрэгжиж эхэлснээс хойш нийт 10.1 их наяд төгрөгийн зээл гарсан ч ЯНДАНГИЙН ТОО БУУРЧ, УТАА АРИЛСАНГҮЙ. Учир нь зорилтот бус боломжтой хүнээ дэмждэг болчихсонд гол асуудал байгаа юм. Ипотекийн зээл нь бодит хэрэгцээтэй, орон сууцгүй айлд очих ёстой болохоос аль хэдийн байртай, хөрөнгөжсөн хэсгийн хөрөнгөө өсгөх “хэрэгсэл” байх учиргүй!

Тодруулбал ипотекийн зээл авсан иргэдийн зарим нь дөрөв, тав дахь байраа авч байхад, анхны байраа авах гэж банкны үүд сахиж, хэдэн сар жилээр дугаарлаж буй гэр бүл маш их байна. Энэ бол яагаад ч шударга зүйл биш. Иймд тус зээлийг зорилтот гэр бүлд шударгаар хүрдэг “шинэ тогтолцоог” бүрдүүлэх зүй ёсны шаардлага байна.

Тиймээс миний бие энэ хүрээнд Эдийн засгийн байнгын хорооны дарга Р.Сэддоржид хандан ипотекийн зээлийн нөхцөл байдал, орон сууцны үнийн өсөлтийн бодит байдлыг судалж, үнэлэх, танилцуулах ажлын хэсэг байгуулах санал гаргасан болно. Улмаар УИХ-ын Эдийн засгийн байнгын хороо 2025 оны зургаадугаар сарын 10-ны хуралдаанаараа тогтоол баталж,



ипотекийн зээлийн хөтөлбөрийн хэрэгжилтийг хянан шалгаж, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж, тус ажлын хэсгийг миний бие ахлан ажиллаж байна.

Ипотекийн зээлийн хөтөлбөрийн хэрэгжилтийг хянан шалгаж, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийн хуралдаанаар Монголбанк, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын болон Сангийн яам, Монголын Ипотекийн корпорацын орон сууцны ипотекийн зээлийн хөтөлбөрийн нийслэл хот болон орон нутагт хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаа, санхүүжилтийн тогтолцоо, орон сууцны төсөл, хөтөлбөрүүдийн талаарх мэдээллийг сонслоо. ■



ИПОТЕКИЙН ЗЭЭЛ ОЛГОЛТ 2025 ОНЫ 9 ДҮГЭЭР САРЫН БАЙДЛААР

10.1

их наяд төгрөгийг зээлийг

139 мянган

өрхөд олгов

17.7 жил

/зээлийн дундаж хугацаа/

2023 оноос 3.0%

орон нутагт хүүгийн татаастай зээл олгож байна



Ипотекийн нийт зээлийн эргэн төлөлтийн ангилал:

95.1%

- хэвийн

4.6%

- хугацаа хэтэрсэн

0.3%

- чанаргүй

Банкны систем дэх зээлийн бүтээгдэхүүнүүдийн дотор ипотекийн зээл өндөр чанартайд тооцогддог.

Шинээр олгосон зээл:

2024 онд 1.5

өмнөх оноос дахин нэмэгдсэн бол

2025 онд 4.9

ипотекийн зээл авах шийдвэрлэгдээгүй хүсэлт хуримтлагджээ.



УИХ-ын гишүүн, ажлын хэсгийн ахлагч Ж.Алдаржавхлан:

Цаашид орлогод суурилсан зорилтот бүлгийг дэмжих, орон сууцжуулалтын бодлогын хүрээнд хөнгөлөлттэй ипотекийн зээлийг зорилтот бүлэгт чиглүүлж, бодит хэрэгцээтэй өрхүүдийн хүртээмжийг нэмэгдүүлж, хэрэгжилтийн хийдлийг арилгахад фокуслаж ажиллах шаардлага бий! ■

“Нийслэл Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг батлах тухай” УИХ-ын тогтоолын төсөл
Өргөн барьсан 2025.01.08



АМЬДРАХАД ТААТАЙ ОРЧИН БҮРДСЭН “АМЬД ХОТ” БҮРДҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨЛТ ХИЙГДЛЭЭ

Улаанбаатар хотын хүн амын тоо эрчимтэй өсөж, эдийн засаг, нийгмийн үйл ажиллагаа идэвхжихийн хэрээр төлөвлөлтгүй суурьших, байгаль орчин доройтох, улмаар иргэдийн эрүүл, аюулгүй амьдрах эрх зөрчигдөхөд хүрч хот төлөвлөлтийн шинэ орчин бүрдүүлж хэрэгжүүлэх шаардлага урган гарч байна. Иймд Монгол Улсын Засгийн газраас “Нийслэл Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг батлах тухай” УИХ-ын тогтоолын төслийг боловсруулж өргөн мэдүүллээ. Уг тогтоолын төслийг УИХ-аар хэлэлцүүлэх ажлын хэсгийг миний бие ахлан ажиллаж байна. ■

“Нийслэл Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө”-г баталж, хэрэгжүүлснээр дараах үр дүн гарна

Хүн амын өсөлт

2024 он - 1,640 сая
2040 он - 2,089 сая



Улаанбаатар хотын хүн ам 1.6 сая байгаа бол 2040 онд 2.8 сая болж өсөх ба үүний 405 мянган хүн амыг дагууд хотуудад суурьших тооцооллыг мэргэжлийн байгууллагуудаас гаргасан.

Ажлын байр

2024 он - 525,000
2040 он - 894,000



Ажлын байрны тоо 1.4 дахин нэмэгдэж, 193 мянган ажлын байрыг шинээр бий болгоно.

Ногоон байгууламж

2024 он - 8м2
2040 он - 35 м2



Нэг хүнд ноогдох ногоон байгууламжийн хэмжээг 8м2-аас 35 м2 болгон нэмэгдүүлж, иргэдийн амарч зугаалах, чөлөөт цагаа өнгөрөөх тохилог орчин бүрдэнэ.

Гудамж замын урт

2024 он - 1,250 км урт зам
2040 он - 17,000 км авто зам



Авто замын сүлжээний бүтцийг хэвтээ 8, босоо 12, тойрог замын 3 замын бүтэцтэй байхаар төлөвлөж, 17,000 км замыг шинээр байгуулна.

Орон сууцны хангамж

**2024 он - орон сууц 56%,
гэр хороолол 44%**
**2040 он - орон сууц 91%,
гэр хороолол 9%**



Улаанбаатар хотын иргэдийн 91% нь төвлөрсөн хангамжтай орон сууцанд, 9% нь сайжруулсан амины сууцанд амьдрахаар төлөвлөсөн.

Дундаж хурд

2024 он - 9 км/ц
2040 он - 22.5 км/ц



Оргил ачааллын үеийн замын хөдөлгөөний дундаж хурд 9 км/ц-аас 22.5 км/ц болж нэмэгдэнэ.

Нийтийн тээвэр


2024 он - 18%
2040 он - 44%




Багтаамж ихтэй нийтийн тээврийн сүлжээг бий болгож өдөрт 1,2 сая зорчигч тээвэрлэж, нийтийн тээврийн хүртээмжийг 2 дахин нэмэгдүүлнэ.

Цахилгаан хангамж

2024 он - 1,169 МВт
2040 он - 5,408 МВт



Улаанбаатар бүсийн цахилгааны эх үүсвэр 1,169 МВт байгаа бол 2040 онд 5,408 МВт болж нэмэгдэнэ. Өсөн нэмэгдэх цахилгаан эрчим хүчний хэрэглээний 30 хувийг сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрээс, үлдсэн хувийн дулаан цахилгаан станцаас хангана.



МОНГОЛ УЛСЫН 2025 ОНЫ НЭГДСЭН ТӨСӨВ АЛДАГДАЛГҮЙ БАТЛАГДЛАА



Улсын Их Хурлын намрын чуулган ирэх оныхоо улсын төсвийг хэлэлцэн баталдаг нь хуулиар тогтоосон үүрэг юм. Гэхдээ 126 гишүүнтэй парламентын намрын чуулган өмнөх намрын чуулгануудын хэвшмэл жишгийг өөрчилж чадсан. Сүүлийн 10 жилд нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого, зарлагын өсөлтийн хувь ойролцоо байгаа боловч дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх зарлагын хувь нь орлогоосоо дунджаар 4 пунктээр илүү байсаар ирсэн.

Улмаар алдагдлыг өр, зээлээр нөхөх замаар шийдвэрлэж, тухайн жилд авсан зээлийн заримыг өмнөх зээлээ төлөхөд, үлдсэн хэсгийг төсвийн алдагдлыг нөхөхөд зарцуулсаар байсан! ■

Монгол Улсын Ерөнхийлөгч 2025 оны улсын төсөвт бүхэлд нь тавьсан хориг нь төсвийг эргэн харах нөхцөл бүрдүүлсний зэрэгцээ төсөв хэлэлцэх дэгийг цаашид сайжруулах шаардлагатайг мөн харууллаа. Үүнтэй холбогдуулан Монгол Улсын 2025 оны төсвийг хэлэлцэх дэгийн тухай нэг удаагийн хуулийг хэлэлцэн баталж, улсын төсвийг өргөн мэдүүлэх, хэлэлцэх, батлах хугацааг тусгай дэгээр зохицуулсан юм. ■

Түүнчлэн миний бие 2025 оны Төсвийн тухай хуулийн ажлын хэсэгт орж УИХ-ын гишүүдтэй хамтран ажилласан юм. Энэ жилийн хувьд төсвөөс нийт 2.4 их наяд төгрөг хэмнэгдэж, улсын төсөв АЛДАГДАЛГҮЙ батлагдсаныг хэлэх нь зүйтэй. ■

Монгол Улсын Засгийн газрын нийт өр

- 2024 онд 35,2 их наяд төгрөг
- 2025 оны төсөвт энэ өр даруй 5.0 их наядар нэмэгдсэн
 - 2010 оноос хойш жил бүр дунджаар 2.5 их наяд төгрөгөөр нэмэгдсэн.

2025 оны төсвийг дахин хэлэлцсэнээр

- Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого, тусламжийн дүн 33.5 их наяд төгрөг буюу ДНБ-ний 35.2%-д хүрсэн
- Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл алдагдалгүй болж, суурь тэнцэл ДНБ-ний 3.3%-ийн ашигтай байх төсвийг баталсан.

АЖЛЫН ХЭСЭГ улсын төсвөөс 76 тэрбум төгрөгийн ХЭМНЭЛТ хийх САНАЛ гаргаж, энэхүү хэмнэгдсэн зардлаар:


- Хавдрын эмнэлгийн зориулалтаар ашиглах объектыг лизингээр авах зардал;
 - Сургууль, цэцэрлэг, дотуур байрны хүүхдийн хоолны зардал;
- 3 ээлжээр хичээллэж байгаа ЕБС-ийн байрны түрээсийн зардал зэрэг нэн тулгамдсан нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд зарцуулагдахаар болсон.



ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭМНЭЛТИЙН БОДЛОГЫГ БОДИТ БОЛГОХ ШААРДЛАГАТАЙ!

Улаанбаатар хот нь дэлхийн хамгийн хүйтэн нийслэл бөгөөд нийтдээ 1,7 сая орчим хүн оршин суудаг. 1990 оноос өмнө баригдсан **1077** блок угсармал орон сууцанд нийтдээ **45** мянган өрх буюу **200** мянган иргэд амьдардаг. Насжилт өндөр, засвар хийх шаардлагатай орон сууцны барилгууд нь халаалтын эрчим хүчний маш өндөр хэрэглээтэй, дулаан алдагдал ихтэй байгаа нь нууц биш! Иймд гадна дулаалга, дээвэр засвар, цахилгаан шатны шинэчлэл хийх зайлшгүй шаардлага үүссэн!


Иймд миний бие уг асуудлыг хөндөж, УИХ-ын гишүүн П.Сайнзоригтой хамтран шийдвэрлүүлэх талаар Ерөнхий сайдад хандан 2024 оны 07 сарын 24-ний өдөр **АЛБАН БИЧИГ** илгээсэн юм. Тодруулбал, дээрх асуудлыг шийдвэрлэхэд шаардагдах **78,3** тэрбум төгрөгийг Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуульд тодотгол хийх тохиолдолд тусгах эсхүл 2025 оны улсын төсөвт тусгах арга хэмжээ авч өгөхийг хүссэн билээ. ■



УБ хотод ашиглалтын шаардлага хангахгүй, яаралтай засвар хийх шаардлагатай **379** орон сууц байна. Эдгээрээс хамгийн өндөр насжилттай нь 1950 онд ашиглалтад орсон **75** жилийн настай орон сууц байна!

Дээврийг засварлаж, гадна ханыг дулаалснаар:

- Барилга тус бүрт 26.8%-ийн дулааны эрчим хүчний хэмнэлт гарч
- Ус, дулаан дамжуулах төвийн дулааны ачаалал 61.5 Гкал цаг буюу 16% буурч
- Иргэдийн эрүүл, аюулгүй, тухтай амьдрах нөхцөл бүрдэнэ



МОНГОЛ-ХОРВАТЫН ПАРЛАМЕНТЫН БҮЛГИЙН ДАРГААР АЖИЛЛАЖ БАЙНА

Хорватын парламентын гишүүн, тус улсын парламент дахь Хорват-Монголын бүлгийн дарга, Предраг Штромар тэргүүтэй төлөөлөгчдийг /2025.06.20/-ний өдөр хүлээн авч уулзлаа. Хоёр орны хооронд дипломат харилцаа тогтоосноос хойших 30 гаруй жилийн хугацаанд олон салбарт үр дүнтэй хамтын ажиллагаа өрнөж ирснийг дурдаж, энэхүү айлчлал түүхэн холбоог шинэ шатанд гаргах боломж гэдгийг онцоллоо.



Уулзалтын үеэр хоёр улсын хууль тогтоох байгууллагын хоорондын харилцааг өргөжүүлэх, парламентын бүлгийн үйл ажиллагааг идэвхжүүлэх, хамтын ажиллагааг боловсрол, эдийн засаг, соёл, батлан хамгаалах болон залуучуудын солилцооны чиглэлд гүнзгийрүүлэх талаар санал солилцлоо.

Хорватын парламентын гишүүн Предраг Штромар, Хорватын талаас оюутан, судлаач солилцох тэтгэлэгт хөтөлбөр хэрэгжүүлэх, соёл урлагийн төв байгуулах, хөдөө аж ахуй, аялал жуулчлал, цахим технологийн салбарт хамтран ажиллах боломжийн талаар тэмдэглээд, Монголын ардчиллын хөгжлийг өндрөөр үнэлж байгаагаа илэрхийлсэн юм.

Мөн энэ үеэр “Далайд гарцгүй хөгжиж буй орнуудын судалгааны төв”-ийг Хорват Улсын санаачилсан “3 тэнгисийн санаачилга”-тай холбох замаар Зүүн Европ руу гарц нээх стратегийн боломжийн талаар ярилцсан. Түүнчлэн талууд парламент хоорондын шууд харилцаа, харилцан айлчлал, боловсрол, судалгаа, энхийг сахиулах ажиллагаа болон хувийн хэвшлийн хамтын ажиллагааг цаашид үр дүнтэйгээр гүнзгийрүүлэн хөгжүүлэх талаар харилцан санал солилцов. ■



УХРААГҮЙ, УРАГШИЛСААР

УРТ ЗАМ ТУУЛЖ “ПАРЛАМЕНТАД” ОРЖ ИРЛЭЭ...

Сайхан өвөлжиж байна уу. Таны хувьд УИХ-ын гишүүнээр сонгогдоод 1.5 жилийн хугацаа өнгөрсөн байна?

Сайхан. Та сайхан өвөлжиж байна уу? Цаг хугацаа хурдан өнгөрч байна шүү. Миний бие Хан-Уул дүүргийнхээ иргэдийн итгэл сэтгэлийг өвөрлөн хууль тогтоох төрийн дээд байгууллагад орж ажиллаад хэдийн 1.5 жилийн хугацааг өнгөрүүлсэн байна. Ингэхдээ УИХ-ын үйл ажиллагааг мэдрэхээс аваад нийгмийн шударга ёсны хүсэмжлэл дээд цэгтээ хүрсэн эгзэгтэй цаг үед хүний эрх, хуульт ёс, шударга байдлын зарчмыг хангасан хууль тогтоомжийг батлан гаргах хариуцлагатай үүрэг бий хэмээн ухамсарлаж байна. Тиймдээ ч парламентын гаргасан хууль тогтоомж бүрт улс орны язгуур эрх ашгийг дээдэлсэн, олон тулгуурт гадаад бодлогыг дэмжсэн, нийгэм эдийн засгийн тогтвортой хөгжилд хөтөлсөн, иргэд ААН-ийнхээ эрх ашгийг хамгаалж, сонгогчдын эрх ашгийн үүднээс асуудалд хандаж ажиллалаа.

“

Хүмүүс хаана амьдарна тэнд ямагт асуудал үүсдэг. Түүнийг шийдэхийн тулд ухаанаа уралдуулж, гарц шийдлийг хайж, бодлого боловсруулах нь хууль тогтоогчийн үндсэн үүрэг.

Өргөн төлөөллөөс бүрдсэн 9 дэх удаагийн парламент хоёр дахь Намрын чуулганы хаалтаа хийлээ. Энэ удаагийн намрын чуулганыг та хэрхэн дүгнэж байна?

УИХ-ын гишүүний хамгийн гол ажил нь хууль батлах. УИХ жилд хоёр удаа чуулдаг. Жил бүрийн 3-р сарын 15-наас 7-р сарын 1 хүртэл хаврын чуулган чуулдаг бол 9-р сарын 15-аас 12-р сарын 31-ний хүртэл намрын чуулган чуулж хуралддаг. Өнгөрсөн намрын чуулган ширүүхэн болж өнгөрлөө. 2025 намрын чуулган 75 өдөр чуулж нийтдээ 14 хууль, 37 тогтоол хэлэлцэн баталлаа. Ингэхдээ ирэх оны төсөв, мөнгөний бодлогыг хэлэлцэн баталсан. Тухайлбал, эмч, багш нарын цалинг ирэх онд үе шаттайгаар 76 хувь, тэтгэврийг инфляцтай уялдуулан 8,6 хувиар нэмэх улсын төсвийг хуульчлан баталсан. Цалин тэтгэвэр сэтгэлд хүрээгүй ч тодорхой түвшинд нэмэгдсэн нь бага ч гэсэн дэвшил хэмээн харж байна. Нөгөө талдаа төсөв тэлж, төр данхайхын хэрээр ард иргэд, аж ахуйн нэгжийн үүрдэг ачаа дарамтыг буулгаж нурууг тэнийлгэхийн төлөө ухаан бодлоо уралдуулсан төсөв байсныг хэлэх нь зүйтэй.

“
**Нийслэлийн
замбараагүй газар
олголт, газрын
наймааг таслан
зогсоох, Туул гол дагуух
хайрга олборлолт
түүнээс үүссэн
орчны бохирдлыг
шийдвэрлэхэд
анхаарна!**



Анх гишүүний тангаргаа өргөхдөө чуулганы индэрт “1000 хүртэлх хүн амтай хотхон, хорооллыг заавал улсын сургууль, цэцэрлэгтэй барих хуулийн төслийг батлуулна” гэх таны амлалт хий хоосон байгаагүйд баяртай байна. Онцгойлон ямар хуулийн төслүүдийг барьж ажиллав?

Миний хувьд дүүргийн түвшинд ажиллаж байсан учир тэнд бидний амьдралд ямар саад бэрхшээл байна, яг тулгамдсан асуудлуудаараа хууль санаачлахыг хичээж байна. Нэг ёсондоо мэддэг юмаа ярьж, түүнийхээ араас явах ёстой гэж үздэг. Тиймдээ ч бүрэн эрхийнхээ эхний 1.5 жилд бие даан болон хамтран санаачилж, боловсруулсан 15 орчим хуулийн төсөлд ажиллалаа.

Тоймловол нэгдүгээрт, Бүтээн байгуулалт, аж ахуйн ажил бүхний цаана хууль, эрх зүйн асуудлууд хөндөгдөж байдаг зүй тогтолтой. Сүүлийн жилүүдэд нийслэл хотод ямар ч төлөвлөлтгүй, улсын сургууль, цэцэрлэггүй, ногоон байгууламж, тоглоомын талбайгүй хорооллууд олноор баригдаж хүн амын хэт төвлөрөл, авто замын түгжрэл газар авсан. Үүнийгээ дагаад сургууль, цэцэрлэгийн хүрэлцээний асуудал хурцаар тавигдсан нь эрх зүйн реформ хийх зайлшгүй шаардлага үүссэнийг илтгэж буй. Улмаар гишүүний ажлаа авсан даруйдаа цэцэрлэг, сургуулийн хүртээмжийг сайжруулах үүднээс Хот байгуулалтын тухай хуулийн



“
**Иргэдтэйгээ эргэх холбоотой
 байж, эхлүүлсэн ажлынхаа
 ард “заавал” гарахыг эрмэлзэн
 ажиллаж байна!**

төсөл дээр шаргуу ажилласнаар 2025 оны 7 дугаар сарын 9-ний чуулганы хуралдаанаар хуулийн төсөл маань эцэслэн батлагдсан. Хоёрдугаарт, Биокомбинат, шувуун фабрик орчмын голын ай сав дагуу зөвшөөрөлтэй болон зөвшөөрөлгүй хайрга дайрга олборлолтыг хориглох хуулийг санаачлан өргөн барьсан. Уг хууль батлагдсанаар иргэдийн амьдрах орчны аюулгүй байдал хангагдаж, голын ай савд нөхөн сэргээлт хийгдэх нөхцөл бүрдэнэ. Үүний сацуу 10 гаран хуулийн төслийн ажлын хэсгийн ахлагч болон гишүүнээр ажиллаж байна.

Хот байгуулалтын бодлогын асуудлаар санал дүгнэлт гаргах, холбогдох хууль тогтоомжийн төсөл боловсруулах ажлын хэсгийг та ахалж байгаа. Ажлын хэсгийн явц байдлын талаар мэдээлэл өгнө үү?

Улсын Их Хурлын даргын 2025 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 523 дугаар захирамжаар Хот байгуулалтын ажлын хэсэг гарсан. Манай ажлын хэсэг Хот байгуулалтаар буюу нийслэл хотын асуудлаар “чөлөөлье” санаачилгын хүрээнд энэ салбарт ямар бэрхшээлүүд байгаа мөн бизнес эрхлэхэд төвөг болоод байгаа асуудлуудыг судалж, улмаар хууль санаачилж, богино хугацаанд батлуулахаар ажиллаж байна. Ажлын хэсэг гурван удаа хуралдаж, судалгаа шинжилгээний ажлыг шат дараатай хийгээд явж байна. Тухайлбал энэ сарын 6-ний өдрийн хуралдаанаар Хот байгуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын хэрэгжилт, ялангуяа шинээр баригдаж буй хотхон, хорооллын төлөвлөлтөд сургууль, цэцэрлэгийг заавал тусгах заалтын хэрэгжилтийн талаар хэлэлцлээ. Мөн Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн хэрэгжилтэд тулгарч буй хүндрэл бэрхшээл, Монгол банкнаас хэрэгжүүлж буй ипотекийн хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөрийн явцын талаар мэдээлэл сонсож, санал солилцсон.



“Хамгийн сайн сургууль гэртээ ойр сургууль гэж би хувьдаа боддог. Тийм ч учраас боловсролын салбарт түлхүү анхаарна.

Ипотекийн зээл залуусын мөрөөдөл болчихоод байгаа нь нууц биш. Та ипотекийн зээлийн хөтөлбөрийн хэрэгжилтийг хянан шалгаж, санал дүгнэлт гаргах ажлын хэсгийн ахалж байгаа. Ажил хэрхэн өрнөж байна?

Ипотекийн зээлийн хөтөлбөр хэрэгжиж эхэлснээс хойш нийт 10.1 их наяд төгрөгийн зээл гарсан ч яндангийн тоо буурч, утаа арилсангүй. Учир нь зорилтот бус боломжтой хүнээ дэмждэг болчихсонд гол асуудал байгаа юм. Ипотекийн зээл нь бодит хэрэгцээтэй, орон сууцгүй айлд очих ёстой болохоос аль хэдийн байртай, хөрөнгөжсөн хэсгийн хөрөнгөө өсгөх “хэрэгсэл” байх учиргүй!

Тодруулбал ипотекийн зээл авсан иргэдийн зарим нь дөрөв, тав дахь байраа авч байхад, анхны байраа авах гэж банкны үүд сахиж, хэдэн сар жилээр дугаарлаж буй гэр бүл маш их байна. Энэ бол яагаад ч шударга зүйл биш. Иймд тус зээлийг зорилтот гэр бүлд шударгаар хүрдэг “шинэ тогтолцоог” бүрдүүлэх зүй ёсны шаардлага байна. Энэ хүрээнд манай ажлын хэсэг Монголбанк, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын болон Сангийн яам, Монголын Ипотекийн корпорацын орон сууцны ипотекийн зээлийн хөтөлбөрийн нийслэл хот болон орон нутагт хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаа, санхүүжилтийн тогтолцоо, орон сууцны төсөл, хөтөлбөрүүдийн талаарх мэдээллийг сонссон. Цаашид орлогод суурилсан зорилтот бүлгийг дэмжиж, орон сууцжуулалтын бодлогын хүрээнд хөнгөлөлттэй ипотекийн зээлийг зорилтот бүлэгт чиглүүлж, бодит хэрэгцээтэй өрхүүдийн хүртээмжийг нэмэгдүүлж, хэрэгжилтийн хийдлийг арилгахад фокуслаж ажиллана.

УИХ-ын гишүүний чухал хариуцлагатай үүрэг бол тойргийн иргэдийн дуу хоолойг парламентын индэрт хүргэхэд “гүүр” нь болох. Мөн тэдэнд тулгамдаад буй асуудлыг шийдвэрлэхэд оршдог?

тогтоохоос гадна сонгогдсон тойргийнхоо нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд гар бие оролцож, шаардлагатай хөрөнгө мөнгийг улсын төсөвт суулгах үүрэгтэй. Миний хувьд хууль тогтоох дээд байгууллагад Хан-Уулчуудийн итгэлийг хүлээн орсноос хойш тойргийнхоо иргэдтэй нийтдээ ... удаа уулзсан байна. Цаашдаа ч тойрогтоо ажиллаж, иргэд сонгогчдын санал хүсэлтийг сонсон, тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, хуулийн төсөлд тусгах санал санаачилгыг дэмжин ажиллана.

Хан-Уул дүүргийн хэмжээнд өрнүүлж, иргэдийн өмнө тулгамдсан асуудлыг шийдвэрлэсэн томоохон бүтээн байгуулалтын ажлын тухай мэдээлэл өгнө үү?

2025 онд Хан-Уул дүүрэгт Засаг дарга байхдаа эхлүүлсэн ажлууд маань эхнээсээ хэрэгжээд явж байна. Заримаас нь дурдвал, Яармагийн иргэд Нисэхийн тойрог дээр түгжирч, үнэт цагаа зам дээр өнгөрүүлдэг байсныг Засаг дарга байхдаа шийдэж, тойргийг дөрвөн замын уулзвар болгосон. Одоо яармагийнхан тэнд гацахаа больсон. Нисэхийнхэн зэвтэй ус уудаг байсныг шугам хоолойг нь шинэчлэснээр иргэд маань одоо “цэвэр ус” ууж байгаа. Солонго | || хорооллынхон сургууль цэцэрлэггүй байсныг хөөцөлдөж гүйсээр барилгын сайдаар асуудлыг шийдүүлсэн гээд иргэдтэйгээ эргэх холбоотой байж, эхлүүлсэн ажлынхаа ард заавал гарахыг эрмэлзэн ажиллаж байна.

Түүнчлэн Хан-Уул дүүрэгт татсан хөрөнгө оруулалтаа харвал чамлахааргүй төсөвт сууж, энэ жил Хан-Уул дүүрэгт бүтээн байгуулалтын жил байна гэдгийг дуулгахад таатай байна. Тухайлбал, манай дүүрэгт 2025 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 7 сургууль, 4 цэцэрлэг шинээр ашиглалтад орсон бол нэмээд 2026 онд улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр шинээр 15 сургууль, 8 цэцэрлэг, 3 бага сургууль цэцэрлэгийн цогцолбор, 14 байршилд 23.7 км хатуу хучилттай авто зам, 5 байршилд 4.6 км инженерийн дэд бүтэц шинээр баригдахаар төлөвлөгдөж байна.

Ирэх 2026 оны Хаврын ээлжит чуулганд хийж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө тань юу байна вэ?

Хэд хэдэн хуулийн төсөл хэлэлцэхүүлэхээр бэлдсэн байгаа. Мөн ахалсан ажлын хэсгийнхээ ажлуудыг, тойрогт хэрэгжиж байгаа эхүүлсэн ажлуудынхаа явц хэрэгжилт дээр анхаарах зэрэг олон ажлуудыг хийхээр төлөвлөсөн. ■



УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаан, Байнгын хороодын хуралдаанд илэрхийлсэн ОНЦЛОХ БАЙР СУУРЬ

Иргэдийн цалин хөлс амьдралд нь хангалттай, амьдрах орчин нь аюулгүй, эрүүл байх нь нэн чухал!

Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр
УИХ-ын чуулган 2024.08.16

Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг дэмжих байгаа. Гэхдээ дараах зүйлсийг анхаарах ёстой. Монголчууд хэзээ аз жаргалтай байх вэ гэвэл нэгдүгээрт, цалин хөлс нь амьдралд нь хүрэлцэхүйц хангалттай. Хоёрт, амьдрах орчин аюулгүй тааламжтай. Гуравт, эрүүл саруул байх ёстой. Хот нийтийн аж ахуйн ажилтнуудын цалин нэмэгдээд 3,5 сая төгрөгт хүрсэн. Ядаж нийт төрийн албан хаагчдынхаа цалинг энэ зэрэгт хүргэмээр байна. Үүний дараа засаг захиргааны шинэчлэлийг зайлшгүй хийх шаардлагатай!

Монголын нүүрсийг сорчлохгүй гэдгийг хэлэлцээрт оруулах ёстой!

Гашуунсүхайт-Ганцмод боомтын хил дамнансан төмөр зам, нүүрсний худалдаа, Тавантолгойн нүүрсний уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх хамтын ажиллагааны тухай хэлэлцээр
ЗЗБХ-ны хурал 2025.01.27

Энэ хэлэлцээр нь зөвхөн төмөр замын хэлэлцээр биш болчихсоныг бүгд ойлгож байгаа. Хэлэлцээр хийхэд Монголд нэг зовлон бий. Нүүрс сайхан гараад, валютын орлого нэмэгдээд явж байтал гэнэт БНХАУ-ын тал нүүрс авахаа больчихдог. Үүнээс үүдээд валютын ханш савладаг, эдийн засагт хор нөлөө учирдаг. Иймд гэрээний хэлэлцээрт тогтвортой байлгах тухай асуудлыг тусгах нь нэн чухал. Монголын нүүрсний чанартай хэсгийг нь аваад, чанаргүйг нь үлдээчихдэг. Чанаргүй хэсгийг нь яах юм. Тэгэхлээр сорчлохгүй гэдгийг хэлэлцээртээ оруулах шаардлагатай.

ЭТТ-н компанийн захирлууд Монголын хамгийн баян хүн болтлоо баяжсан!

Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнансан төмөр зам, нүүрсний худалдаа, Тавантолгойн нүүрсний уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх хамтын ажиллагааны тухай хэлэлцээр
ЗЗБХ-ны хурал 2025.01.27

Цаашдаа ЭТТ компани энэ ажлыг хариуцах юм байна. Өмнө ЭТТ-н компанийн захирлууд Монголын хамгийн баян хүн болтлоо баяжсаны дээр монголын хамгийн их асуудлыг үүсгэж байсан. Одоо тэд бүгдээрээ зохих ёсны хуулийн хариуцлага хүлээчихсэн явж байгаа. Яг энэ замаар ахин орохгүй гэсэн баталгаа байгаа юу. Өмнөх хүмүүсийн алдааг давтахгүй байх чиглэлд бодож, төлөвлөж байгаа юу. Эсхүл гаднын өндөр боловсролтой мэргэжилтнүүдийг авчирч болдоггүй юм уу. Заавал хүмүүсийн гар хөл болсон хүмүүсийг томилох шаардлага байна уу!

Хоёр хотыг эрх зүйн хувьд нэгтгэх нь зүйтэй!

Хархорум хотын бүтээн байгуулалт, хөгжлийг дэмжих тухай хуулийн төсөл
УИХ-ын чуулган 2025.01.16

Хархорин, Хархорум гээд хоёр хот байгуулагдах гээд байна. Хархорин хот 2024 оны 5 сард батлагдсан хуулиар хот болчихсон. Тэгтэл дахиад Хархорум хот 8 км-ийн зайтай баригдах гэж байна. Нэг рүү нь асар их хөрөнгө оруулалт ороод байдаг. Ерөнхийлөгчийн өргөө очно. Хөгжлийн бүх хөрөнгө оруулалт хийгдэх гээд байдаг. Тэгтэл нөгөө хот нь хэвээрээ үлдэх нь байна. Тиймээс энэ хоёр хотыг хууль эрх зүйн хувьд нэгтгэх нь зүйтэй!

Зовлон дундуур нь туулчихсан хүмүүсийнхээ саналыг нь сонсоорой!

“Нийслэл Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг батлах тухай” УИХ-ын тогтоолын төсөл
ТББХ-ны хурал 2025.01.16

Нийслэл хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг өмнө нь хэдэн удаа УИХ-ын аар баталж байв. Энэ удаагийнх өмнөхөөсөө ямар ялгаатай вэ. 2040 ажлын хэсэгт нийслэлээс сонгогдсон гишүүдийг оруулж өгөхийг хүсэж байна. Учир нь нийслэлд байсан гишүүд зовлон дундуур нь туулчихсан учраас асуудлыг илүү ойлгодог.

Нефтийн үйлдвэрээ барих гэсээр байтал цахилгаан болон ус төрөгчөөр ажилладаг машинууд гараад ирлээ!

Монгол Улс, Олон Улсын сэргээн босголт, хөгжлийн банк хооронд байгуулах “Эрчим хүч-3 төсөл”-ийн Зээлийн хэлэлцээр
ЗЗБХ-ны хурал 2025.01.13

Нэгт, нефтийн үйлдвэрийн барилгын төсөл хэдэн хувьтай явж байна. Хоёрт, нефтийн үйлдвэр бол



монголчуудын хүслийн жагсаалтын хамгийн тэргүүнд байгаа. Монголчууд нефтийн болон шатахууны хараат байдлаас гарья гэж түмэн үеэрээ л бодож байгаа. Гуравт, анх тэрбум 200 сая долларын зээлийн хэлэлцээр байж байгаад өнөөдөр өртөг нь өсөж байгаа аж. Яг бодитой өссөн эсэхийг хөндлөнгийн байгууллагаар шалгуулж үзсэн үү. Нефтийн үйлдвэр яг хэдэнд орох вэ. Ингэсээр байтал нефть бараг хэрэггүй болоод цахилгаан болон устөрөгчийн машин гараад ирнэ.

Хүний Эрхийн комиссын ажилтнуудыг эрүүдэн шүүлтийг зогсоох эрх мэдэлтэй болгомоор байна

“Эрүүдэн шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандахаас ангид байх хүний эрхийн хэрэгжилт” хяналтын сонсголын тайлан
ХЗБХ-ны хурал 2024.12.18

Бид нүүрсний сонсгол, ногоон автобусны сонсгол, эрүүдэн шүүлтийн эсрэг сонсголыг хийсэн. Сонсголыг хоёр үе шаттай хиймээр байна. Ингэхдээ хуульдаа өөрчлөлт оруулаад эхлээд хяналтын сонсгол, нэг жил орчмын >>

дараа үр дүнгийн сонсгол хийдэг баймаар байна. Тэгэхгүй бол яг ямар ажил хийгдсэн нь тодорхойгүй баахан хүмүүс ирж зовлонгоо ярьж байгаад явдаг. Хоёрт, ХЭҮК гэж “шүдгүй” байгууллага бий. Тухайн хүн хорих дотроос намайг эрүүдэн шүүгээд байна гэдэг мессежийг өгвөл ХЭҮК-т түдгэлзүүлэх эрхийг нь өгмөөр байна. Эрүүдэн шүүлтийг хамгийн торгон мэдрэмжээр мэдрэх байгууллага бол ХЭҮК юм.

Нийслэл хотыг газан дулаанаар халаах ажлын тооцоолол ямар байгаа вэ?

Сэргээгдэх эрчим хүчний төслүүд болон эрчим хүчний үнэ, тариф, эрчим хүчний салбарын өнөөгийн нөхцөл байдал
ЭЗБХ-ны хурал 2024.12.19

Нийслэл хотыг газрын дулаанаар хангая гэдэг асуудал дээр дооргүй яригдаж эхэллээ. Энэ үнэхээр боломжтой юу. Эрчим хүчнээс хараат амьдарна гэдэг нь “хөлөө тушуулчихсан адуу”-тай адил. Эрчим хүчний зохицуулах хороо яг юу хийдэг байгууллага юм. Зөвхөн тариф нэмж, тусгай зөвшөөрөл олгодог юм уу!

Төрийн албан хаагчдын цомхотголд болгоомжтой хандаарай. Ард нь амьдрал бий шүү!

Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
УИХ-ын чуулган 2025.06.23

Төрийн албан хаагчдыг цомхотгох асуудалд маш болгоомжтой хандаарай. Үүний ард олон хүний амьдрал явж байгаа. Хий хоосон орон тоонуудыг цомхотгох чиглэлд ажиллахгүйгээр байгаа орон тоон дээр ажиллаж буй алба хаагчдыг халах нь эрсдэл дагуулна.

Энэ хуулийн гол зорилго нь хүний эрх, хүүхдийн эрхийг хангах

“Хот байгуулалтын тухай хууль
УИХ-ын чуулган 2025.06.13

Улаанбаатар хотод сургууль, цэцэрлэггүй төлөвлөлтүүд олширсон. Нэг ёсондоо дабл стандарт нь мөрдөгдөөд байна. Иймд сургууль, цэцэрлэгийг заавал хуульд оруулж байж хотхон хорооллыг төлөвлөх нь зүйтэй. Ингэхдээ 1000 хүртэл хүн амтай хороололд нэг улсын сургууль байх ёстой.

Ардчилсан нам засгаас гарах нь тодорхой болсон. Яамдыг нь татан буулгаад зардлыг нь таяна!

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай
УИХ-ын чуулган 2025.05.29

Төсвийн урсгал зардлаа бууруулаад хөрөнгө оруулалтын зардлаа нэмэх чиглэлд судалгаа



шинжилгээ хийвэл яасан юм. Төсвийн урсгал, зардлаа бууруулахгүй болохоор хөрөнгө оруулалт нэмэгдэхгүй байна. Амласан ажил их байна. Засгаас Ардчилсан нам гарах нь тодорхой болчихсон. Тиймээс яамдыг нь татан буулгаад, төсвийн зардлаа хэмнэж болохгүй юу. Яамгүй сайдаар юу хийхэв. Олон шадар сайдын ч хэрэг алга.

Монгол Улсын засаг захиргаанд шинэчлэл хийх шаардлагатай!

Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль
УИХ-ын чуулган 2025.05.16

ЗГ-ын мөрийн хөтөлбөрт орсон маш том ажил нь “20 минутын хот”. Үүнийг хэрэгжүүлэх үндэс нь Хот тосгоны хууль. Энэ хууль дахиад хойшилбол 20 минутын хот Үндэсний хорооны ч хэрэггүй. 1992 оноос хойш 30 гаруй жил явж буй Монгол Улсын засаг захиргаанд шинэчлэл хийхгүй л бол болохоо байчхаад байна. Ажил хийдэггүй, хүн ордоггүй төрийн байгууллагууд их болчихсон. Тэд нарыг өөрчилье, цомхотгоё, нэгтгэе, эрх мэдлийг нь шилжүүлж өгье.

Удирдлагын академийн статус дээр “аудит” хийх шаардлагатай!

УИХ-ын чуулган 2025.05.08

Удирдлагын академи гээд статус нь ойлгомжгүй байгууллага бий. Ахлах сургууль эсхүл ТӨК ч юм шиг. Нэг гараараа оюутнуудаас төлбөр авдаг, нөгөө гараараа улсын төсвөөс татаас авдаг. Энэ байгууллагын статусын асуудлыг нэг тийш нь болгомоор байна. Төрийн албыг мэргэшүүлэх академи эсхүл өөрийнхөө сургалтын төлбөрөөр үйл ажиллагаа явуулдаг МУИС шиг сургууль болгох ёстой.



Үндэсний гурил үйлдвэрлэгчид улсаас хөнгөлөлттэй зээл авчхаад ямар ч хариу "үйлдэл" үзүүлэхгүй байна!

Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль
УИХ-ын чуулган 2025.04.24

Бид үндэсний гурил үйлдвэрлэгчдийг дэмжжээ гээд зорьж байна. Үндэсний гурил үйлдвэрлэгч ААН-үүд өнгөрсөн 3 жилд гурилынхаа үнийг тогтвортой барина гээд улсаас 101 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл авсан. Гэтэл өнгөрсөн жил гурилын үнэ 3000 төгрөгт хүрсэн. Бид үндэсний гурил үйлдвэрлэгчдээ бодоод байдаг. Гэтэл нөхдүүд улсаас авсан хөнгөлөлттэй зээлийнхээ хариуд ямар ч үйлдэл үзүүлэхгүй байна!

Төсвийн зардлын огцом өсөлтүүдийг хязгаарлая

Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнансан төмөр зам, нүүрсний худалдаа, Тавантолгойн нүүрсний уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх хамтын ажиллагааны тухай Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төсөл
УИХ-ын чуулган 2025.03.27

Монгол Улс олдог орлогынхоо 93%-ийг нь нүүрс, зэсээр олж байна. Ойрын ирээдүйд ч үүгээрээ л амьдрах байх. Төсвийн зардлынхаа огцом хүсэлтийг хязгаарлавал яасан юм. Өнгөрсөн жил 27 их наяд байсан төсөв энэ жил 33 их наяд болсон. Бизнес эрхлэгчдийн хүсэж байгаа зүйл

нь ханшийн тогтвортой байдал. Үүнийг хангахын тулд төсвийнхөө зардлын огцом өсөлтүүдийг хязгаарлая. Төсвийн зардлын огцом өсөлтүүд бүгд гадагш валют болж гараад байна!

Ипотекийн зээлийн дараалал, авлигын асуудал хэрээс хэтэрлээ!

Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төсөл
ЭЗБХ-ны хурал 2025.10.07

Хуримтлалын сангаас 2024 онд ипотекийн зээлийн санхүүжилтэд нь 467 тэрбум төгрөг тооцсон. 2026 онд энэ дүн хэд байх вэ. Ипотекийн зээлийн дараалал, авлигын асуудал хэрээс хэтэрлээ. Би ажлын хэсгийг ахлаад ажиллаж байгаа. Энэ ажилд Сангийн яам огт оролцохгүй шахуу байна. Хэзээ ажилдаа ирж, идэвх сэтгэлтэй оролцох вэ! Ирэх жил ипотекийн зээлийн санхүүжилтийн дүнг харж байгаад бид ипотекийн зээлийн "цоо шинэ бодлого" гаргахгүй бол арилжааны банкууд зөвхөн өөрийнхөө санхүүжүүлж байгаа барилгаас авсан нөхцөлд зээлээ өг гэж шахдаг. Эсхүл дараалал урагшлуулахын тулд авлига авдаг тухай иргдээс гомдлууд ирсэн.

Багш, эмч хамгийн өндөр цалинтай байх ёстой

ЭЗБХ-ны хурал 2025.10.07

Миний хувьд боловсролын салбарт ойр ажилладаг. Манай улс цөөхөн хэдэн багш нараа БНСУ-руу алдаад дууслаа. Хамгийн сайн багш нар хаана байдаг вэ гэвэл тогтвортой ажилладаг багшийг л хэлнэ. Тиймээс эмч, багш нарынхаа цалинг нэмэхтэй 100% санал нэгдэж байна.

Хуулийн хэрэгжилт туйлын хангалтгүй байна!

Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хууль
УИХ-ын чуулган 2025.09.18

Хот байгуулалтын тухай хуулийн хэрэгжилт туйлын хангалтгүй байгаа. Яармаг, нисэхийн дэнжээр дүүрэн 2-3 мянган айлын хотхон, хороолол огт сургуульгүй баригдаж байна. Ерөнхий сайд албан даалгавар гаргаж, энэ хуулийн хэрэгжилтийг хангаж өгнө үү.

Тусгай зөвшөөрөл олгогчоод араас нь хяналт тавьдаггүй байгууллагуудыг цэгцэлье!

Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл
ЭЗБХ-ны хурал 2025.12.23

Орон сууцны конторын тусгай зөвшөөрлийг нь усны зохицуулах хороо өгдөг. Тэгсэн мөртөө асуудал үүсэхээр нийслэл, дүүргийн ЗДТГ хариуцлага үүрдэг байж болохгүй. Мөн >>

эрчим хүчний зохицуулах хороо нь зөвхөн үнэ нэмэхээр л гарч ирдэг хоттой хамааралгүй сонин байгууллага бий. Зөвхөн тусгай зөвшөөрлийг өгдөг, зовлон болохоор алга болчихдог байх жишээний. Энэ мэт байгууллагуудын асуудлыг хуулиар зохицуулмаар байна.

Тусгай зөвшөөрлөөс илүү бүрдүүлэх материалын жагсаалт хүндрэл учруулж байна!

Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл УИХ-ын чуулган 2025.12.26

Тусгай зөвшөөрөл өгдөг хүнээс илүү тусгай зөвшөөрлийг бүрдүүлэх материалууд нь иргэдийг зовоож байна. Найман нэрийн барааны дэлгүүр, цайны газар ажиллуулах гэхээр эрүүл мэндийн газар, ХХААГ г.м газраас ажлын байрны дүгнэлт гэж айхтар юм авдаг. Ажлын байрны дүгнэлтийг авахын тулд нэг байцаагчийг маш удаан хүлээдэг. Архины зөвшөөрөл авахад галын аюулгүй байдлын дүгнэлт, ажлын байрны дүгнэлт, дүрс бичлэгийн тодорхойлолт гэх мэт материалыг бүрдүүлэхэд 3-4 сар болдог. Эдгээрийг цахимжуулмаар байна.

Иргэд хайрга, дайрга олборлуулахыг хүсэхгүй байвал гомдлоо гаргах эрхтэй

Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль УИХ-ын чуулган 2025.12.19

Туул голын баруун тийш гарвал дайн болчихсон мэт байгаа. 46 ААН хайрга, дайрга олборлохгоод орхиод явчихсан. Шувуун фабрикийн айлуудын хашаанд нь тулаад хайрга олборлож байх жишээний. Энэ асуудлыг шийдэхгүй бол иргэдийн эрүүл, аюулгүй амьдрах орчин зөрчигдөж байна. Уул уурхай, ашигт малтмалын олборлолтын бүсэд амьдарч буй иргэд орчиндоо ямар нэгэн ашигт малтмал буюу хайрга, дайрга олборлуулахыг хүсэхгүйн дээр өөрийнх нь эрхийг зөрчиж байвал гомдлоо гаргах эрх нь нээгдэж байгаа. Хуучин тийм юм байгаагүй.

Сум, дүүргийн иргэдийн хурлын төлөөлөгч цалин, урамшуулалгүй. Энэ хэвээр явбал мөнгөтэй хүн л сум, дүүргийн ИХ-д сууна!

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл УИХ-ын чуулган 2025.12.12

Сум, дүүргийн иргэдийн хурлын төлөөлөгч нэгт, ажил хийж болохгүй, хоёрт, цалин байхгүй, гуравт, урамшуулалгүй. Энэ байдал цаашдаа үргэлжилбэл мөнгөтэй хүн л сум, дүүргийн иргэдийн хуралд сууна. Жирийн дэргийн албан хаагч буюу багш, эмч, салбараа төлөөлж хуралд суух ямар ч бололцоогүй. Иймд нийслэл,

дүүргийн иргэдийн хурлыг нэгтгэж, сум аймгийн иргэдийн хурлыг доороос нь сонгодог болох хэрэгтэй.

Олон төрлийн бүтээгдэхүүн гаалийн тарифгүй орж ирэхэд, ямар үр дагавар гарах вэ!

Монгол Улс болон Евроазийн эдийн засгийн холбоо, түүний гишүүн орнууд хоорондын худалдааны түр хэлэлцээрийг соёрхон батлах тухай хууль

367 төрлийн бүтээгдэхүүн гаалийн тарифгүй орж ирнэ гэх. Монголын хүнсчид үүнтэй өрсөлдөхөд бэлэн үү. Монголчууд махаа гадагш чөлөөтэй гаргавал дотоодын хэрэглээ хүнд байдалд орох юм биш биз! Гаднаас олон төрлийн бүтээгдэхүүн гаалийн тарифгүй орж ирэх нь ямар үр дүнд хүргэх вэ.

Сургууль, цэцэрлэгээс 500 метрийн зайд тамхи татахыг хориглосон заалтыг багасгаж болохгүй!

Тамхины хяналтын тухай хууль 2025.11.28 /зөв.мн/

Тамхины хяналтын тухай хуулийг зарчмын хувьд дэмжиж байгаа. Гэхдээ тамхийг сургуулийн бүсээс 500 метрийн зайд татахыг хориглосон зайг ойртуулах талаар ярьж буйг эсэргүүцэж байна. Зайг ойртуулна гэдэг нь "хүүхдүүдийг тамхи тат" гэж байгаагаас өөрцгүй. Тамхи том зах зээл, том бүлэглэл юм билээ. Асуудал ярих тоолонд ямар нэг нөлөө орж ирдэг.

ХУД-ийн 15-р сургуулийн үлдэгдэл санхүүжилтийг хасаж, улс төрчдийн тойрогт шагнал хэлбэрээр олгосныг тодруулна!

2025.11.06 /хэвлэл/

Улсын төсвөөр хэрэгжин 12-р сард хүүхдүүдээ авах байсан сургуулийн үлдэгдэл 3 тэрбум төгрөгийг төсвөөс хасчихсан. Улмаар тухайн мөнгийг нэр бүхий улс төрчдийн тойрогт шагнал хэлбэрээр тавьж. Хүүхдэд Үндсэн хуулиар олгосон сурч боловсрох эрхийг хангах чиглэлд хийгдэж буй ажлын хөрөнгө оруулалтыг шударга бусаар өөрчилсний шалтгааныг тодруулна.



ХАН-УУЛ ДҮҮРЭГТ 2024-2025 ОНД ХЭРЭГЖСЭН БОЛОН ХЭРЭГЖИЖ БАЙГАА ОНЦЛОХ АЖЛУУД



1. Нисэхийн уулзварын шинэчлэл
2. Хан-Уул дүүргийн Жишиг Нэгдсэн эмнэлгийн барилга
3. Яармаг орчмын хотхонуудын зэвтэй усны шугамын шинэчлэлт
4. Ээрмэлийн гудамжийг Туул гол гудамжтай холбох авто зам
5. Сургуулийн барилга, 960 суудал /17-р хороо/
6. Сургуулийн барилга, 960 суудал /23-р хороо/
7. Сургуулийн барилга, 640 суудал /18-р хороо/
8. Сургуулийн өргөтгөл, 640 суудал /15-р хороо/
9. Сургуулийн барилга, 640 суудал /8-р хороо/
10. Сургуулийн барилга, 640 суудал /16-р хороо/
11. Бага сургууль, цэцэрлэгийн цогцолбор /24-р хороо/
12. Бага сургууль, цэцэрлэгийн цогцолбор /16-р хороо/
13. Бага сургууль, цэцэрлэгийн цогцолбор /12-р хороо/
14. Бага сургууль, цэцэрлэгийн цогцолбор /14-р хороо/
15. Хүүхдийн цэцэрлэг, 240 ортой /1-р хороо/
16. Хүүхдийн цэцэрлэг, 200 ортой /15-р хороо/
17. Цэцэрлэгийн өргөтгөл /5-р хороо/
18. Цэцэрлэгийн өргөтгөл /1-р хороо/
19. Хүүхдийн цэцэрлэг, 130 ортой /23-р хороо/
20. Хүүхдийн цэцэрлэг, 100 ортой /20-р хороо/

ХАН-УУЛ ДҮҮРЭГТ 2026 ОНД УЛС, ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨӨР ХЭРЭГЖИХ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ




15
Сургуулийн барилга

/8640 суудал/

8
Цэцэрлэгийн барилга

/1560 ор/




3
Бага сургууль, цэцэрлэгийн цогцолбор барилга

/540 суудал, 300 ор/

14 байршилд
Хатуу хучилттай авто зам

/23.7 км/



5 байршилд
Инженерийн дэд бүтэц

/4.6 км/





Нисэхийн тойргийг гэрэл дохиотой уулзвар болгов

Нисэхийн тойргийг гэрэл дохиотой уулзвар болгосон ажилтай газар дээр нь танилцлаа. Тэрбээр ХУД-ийн Засаг дарга байхдаа Нисэх орчмын иргэдийн хамгийн их тулгамдаж байсан асуудал болох нисэхийн аюулгүйн тойргийг гэрлэн дохиотой болгох ажлыг анх санаачлан эхлүүлж, өнөөдөр ажил хэрэг болсон юм.

Нисэхийн тойргийг 4 замын уулзвар болгосноор түгжрэл бодитой буурч замын цагдаа нарын ачааллыг хөнгөвчилсөн. Мөн аваар ослоос урьдчилан сэргийлж иргэдийн аюулгүй зорчих нөхцөлийг бүрдүүлсэн бодит ажил болсон гэдгийг тус дүүргийн иргэд хэлж байна.

Өмнө нь аюулгүйн тойрог байх үед заавал дөрвөн талд нь 4 алба хаагч зохицуулдаг байсан. Өнөөдөр ийн 4 замын уулзвар болсноор гэрлэн дохиогоор зохицуулалт хийгдэхийн сацуу зам тээврийн осол багассан юм.

Дээрээс нь ганц алба хаагч уулзварын гол зохицуулалт хийгээд төвөөс гадагш буй хөдөлгөөнийг зохицуулах бүрэн боломжтой боллоо. Ийнхүү дараагийн ээлжид олон түвшний уулзвар болох ажил хийгдсэнээр төсөл иж бүрэн хэрэгжиж дуусах юм. ■



4 ЯАРМАГ ОРЧМЫН ХОТХОНУУДЫН ЗЭВТЭЙ УСНЫ ШУГАМЫН ШИНЭЧЛЭЛ

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ:

• ТЕНДЕРИЙН ШАТАНД БАЙНА.

— "ЦИ АЙ АЙ ЭМ" ХОХ-н барьсан шугам

— "АР ИЙ СИГ" ХОХ-н барьсан шугам

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЭХ ҮҮСВЭР:

• НИЙСЛЭЛИЙН ТӨСӨВ.



Яармаг орчмын зэвтэй усны асуудлыг шийдэх зорилгоор 4.8 км шугамыг шинээр солив

Яармаг орчимд буюу Хан-Уул дүүргийн 23, 24 дүгээр хорооны нутаг дэвсгэрийг дамнансан 4.8 км цэвэр усны үндсэн шугамыг зөв үүсгэхгүй хоолойгоор шинэчилж дууслаа. Тодруулбал,

Хан-Уул дүүргийн 23, 24 дүгээр дээрх хороодын оршин суугчдаас зэвтэй ус гардаг талаарх санал гомдол нэлээдгүй ирдэг байсан. Үүний дагуу Яармаг бүсийн цэвэр усны шугамыг шинэчлэх ажлыг шат дараатайгаар хийж гүйцэтгэж дуусгав. Тодруулбал, 2024 онд ХУД-ийн 23, 24 дүгээр хороодын нутаг дэвсгэрийг дамнансан 4,8 км цэвэр усны шугамын ажлыг бүрэн шинэчилж, шинэ шугамаар цэвэр усыг

хэрэглэгчдэд хүргэлээ. Яармагт шинээр сольсон уг 4.8 км үндсэн шугамын эх үүсвэрээс тухайн орчмын 500 гаруй барилга, байгууламж цэвэр усаа авдаг.

Зөвхөн цэвэр усны төв шугамыг шинэчлээд зогсохгүй Яармаг орчмын орон сууцны хорооллууд, барилгуудын ашиглалтыг хариуцагчид, орон сууцны контурууд дотор шугам сүлжээндээ засвар үйлчилгээ, угаалга зэргийг тогтмол хийх шаардлагатай юм. Ингэснээр зэвтэй усны асуудал бүрэн шийдэгдэх юм. ■



УИХ-ын гишүүн Ж.Алдаржавхлан:

Миний бие Нийслэлийн Иргэдийн Хурлын төлөөлөгч байхдаа 2023 оны 12 сарын 5-ны өдөр нийслэлийн төсөв батлахад 6 тэрбум төгрөгийг суулгаж байсан юм. 4.8 км цэвэр усны шугамын ажил гүйцэтгэх тендерийг 3 удаа зарлахад компаниуд материал ирүүлээгүй. Аргаа бараад УСУГ-т санал тавьж улмаар Ус сувгийн удирдах газраас ажлыг хүлээн авч, гүйцэтгэсэн юм. Ингэхдээ ажлыг богино хугацаанд яаралтай хийж дуусгах үүднээс дотоод зохион байгуулалтаа хийгээд 3 бригадын зохион байгуулалтаар нийтдээ 4.8 км шугам сүлжээг угсарч дуусгаад байна.



Хан-Уул дүүргийн нэгдсэн эмнэлгийн барилга ашиглалтад орлоо

Хан-Уул дүүргийн хөрөнгө оруулалтаар Нэгдсэн эмнэлгийн өргөтгөл ашиглалтад орж, нээлтээ хийлээ. Хан-Уул дүүргийн Нэгдсэн эмнэлгийн шинэ өргөтгөлийн барилга ашиглалтад орсноор дүүргийн иргэдэд эрүүл мэндийн тусламжийг чанартай, түргэн шуурхай, тэгш хүртээмжтэй хүрэхийн зэрэгцээ өвчтөнд шаардлагатай байгаа диализын өдрийн химийн эмчилгээ, үйлчилгээ хийгдэх бүрэн боломжтой болж байна. Энэхүү жишиг эмнэлэг нь 300 хүний ортой бөгөөд тус эмнэлэгт нийт 600 эмч, эмнэлгийн ажилтнууд ажиллах бөгөөд эрүүл мэндийн цогц үйлчилгээг үзүүлэх юм. ■



Ээрмэлийн гудамжийг Туулын гудамжтай холбосон автозам ашиглалтад орлоо

“Орхон” их сургуулиас урагш 115 дугаар сургууль хүртэл буюу Ээрмэлийн гудамжийг Туулын гудамжтай холбох ажил дууслаа. Ээрмэлийн гудамжийг Туул гол гудамжтай холбосон 0.6 км авто замын зорчих хэсэг нь долоон метр өргөн, хоёр талаараа 1.5 метр өргөн явган хүний замтай. Мөн ус зайлуулах шугам хоолойг угсарсан юм. Ээрмэлийн гудамжны авто зам ашиглалтад орсноор өглөө, оройн оргил ачааллын үед Туул голын гудамжнаас Зайсангийн гудамж руу зүүн гар тийш эргэх хөдөлгөөн багасаж, ХААИС-ийн уулзвар чиглэлээс Зайсангийн гудамжаар Чингисийн өргөн чөлөө рүү зорчиж байгаа тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд саад болох нь багасах юм. Мөн Туул голын гудамжнаас Чингисийн өргөн чөлөө рүү зорчих иргэд Ээрмэлийн гудамжаар зорчиж, Ази-Фарм эмийн сангийн гурван замын уулзварын огтлолцлын цэг багасаж, хөдөлгөөний аюулгүй байдалд үзүүлэх эерэг нөлөө нэмэгдэнэ. ■



23-р хороонд 960 хүүхдийн сургуулийн барилга ашиглалтад орно

ХУД-ийн 23 дугаар хороонд шинээр баригдаж буй 960 хүүхдийн шинэ сургуулийн барилга угсралтын ажлын явцтай танилцлаа. 23 дугаар хороонд улсын нэг ч сургууль байхгүйн дээр Байгаль орчны яамнаас сургуулийн газар шийдвэрлэж өгөхийг удаа дараа хүсэлт гаргасан ч шийдэгдэлгүй байсаар ирсэн. Иймд тэрбээр дүүргийн засаг даргаар ажиллаж байх хугацаандаа хувийн хэвшилтэй хамтран газрын асуудлыг шийдвэрлэн, санхүүжилтийг төсөвт суулгаснаар сургуулийн барилга угсралтын ажил эхэлсэн юм. Цаашид ХУД-ийн 23-р хороонд 240, 150 хүүхдийн цэцэрлэг барих зардал төсөвт суугаад байна. ■



18 хороонд 640 хүүхдийн сургууль барих газрын асуудлыг эцэслэв



Хан-Уул дүүргийн 18 дугаар хороо нь Улаанбаатар хотын хамгийн нягтаршил ихтэй, улсын сургууль болон цэцэрлэг хүртээмжгүй хороодын нэг. Тэгвэл УИХ-ын гишүүн Ж.Алдаржавхлан ХУД-ийн Засаг даргаар ажиллаж байх хугацаандаа 18 дугаар хорооны нутаг дэвсгэрт байршилтай “Номинреолтор” ХХК-ийн эзэмшлийн 69.944 м.кв газраас 7000 м.кв газрыг нийслэл авч, 640 хүүхдийн сургууль барихаар тус компанийн удирдлагуудтай уулзаж, зөвшилцөлд хүрсэн байдаг. Тодруулбал, тус 69.944 м.кв газрыг “Номинреолтор” ХХК 2020 оноос 15 жилийн хугацаатай эзэмшиж байгаа

юм. ХУД-ийн 18 дугаар хороонд сургуулийн насны 3000 гаруй хүүхэд байдаг бөгөөд тус компанийн эзэмшиж буй газрын 7000 м.кв газарт 640 хүүхдийн суудалтай улсын сургууль барих зураг төслийг 2022 онд гаргаж, санхүүжилтийг шийдвэрлэсэн. Гэвч газрын асуудлаар “Номинреолтор” ХХК-тай зөвшилцөлд хүрээгүйн улмаас сургуулийн барилгын ажил эхлээгүй байсан билээ. Тэгвэл энэ асуудал эцэслэгдэж, сургуулийн барилгын ажил 2025 оны хавар эхэллээ. Тус сургууль 2026 оны есдүгээр сарын 1-нд ашиглалтад орохоор төлөвлөгдөж байна. ■





960 хүүхдийн сургуулийн барилгатай танилцаж, тулгамдсан асуудлыг шийдвэрлэв!

Хан-Уул дүүргийн 17 дугаар хороонд харьяалагдах “Маршал таун”, “Ривер гарден”, “Скай гарден”, “Модунтаун хотхон” орчимд ямар ч улсын сургууль байхгүйгээр өнөөдрийг хүрсэн. Энэ асуудлыг УИХ-ын гишүүн Ж.Алдаржавхлан ХУД-ийн Засаг даргаар ажиллаж байх хугацаандаа 960 хүүхдийн сургуулийн барилга барих газрын асуудлыг аж ахуйн нэгж байгууллагатай зөвшилцсөнөөр шийдвэрлэсэн байдаг.

Тэгвэл өнгөрсөн хавар 960 хүүхдийн багтаамжтай уг сургууль босоход тухайн барилга нь 4 давхар байх шаардлага үүссэн. Гэтэл Монгол Улсад улсад мөрдөгдөж буй норм, стандартын дагуу сургуулийн барилга 3 хүртэл давхар байх ёстой. Нэг ёсондоо уг барилга нь 4 давхар байж гэмээ нь тухайн хорооны сургуульгүй байгаа хүүхдүүд төрийн сургуульд бүрэн хамрагдах боломж үүсэх юм. Энэ хүрээнд УИХ-ын гишүүн Ж.Алдаржавхлан үүсээд буй асуудлыг Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Ж.Батсуурьт удаа дараа уламжилсны дүнд асуудлыг шийдвэрлэв. ■



УИХ-ын гишүүн Ж.Алдаржавхлан:

Улсын болон хувийн сургууль барих стандартыг ижил болгох шаардлагатай! Миний хувьд салбарын сайдад үүсээд буй асуудлыг уламжилсан. Тодруулбал, барилгыг 4 давхар болгох тал дээр асуудлыг ярьж, хамтарч ажиллах шийдэлд хүрсэн. Өнөөдөр хувийн сургуулиуд 5 давхар баригдаж байна. Тэгвэл яагаад хувийн сургууль 5 давхар барьж болоод, улсын сургууль 3-аас дээш давхраар барьж болохгүй байна! Хувийнх дээр нэг өөр стандарт, улсынх дээр бас нэг өөр стандарт мөрдөгддөг буюу ялгамжтай байх болохгүй! Үүнээс харахад цаашдаа улсын болон хувийн сургуулийн стандартыг ижил болгох шаардлага байна. Нэг үгээр хэлбэл, Монгол Улсад нэг л стандартаар хүүхдийн сургуульд хандах ёстой. Энэ асуудлыг ч салбарын сайдад уламжилсан.



Эхлүүлсэн ажлуудаа дуусгаж, эргэх холбоотой ажиллаж буйд иргэд талархал илэрхийллээ

2025 оны Намрын чуулган завсарласан үеэр УИХ-ын гишүүн Ж.Алдаржавхлан тойрогтоо эхлүүлсэн ажлынхаа үр дүн, явц хэрэгжилттэй танилцан ажиллав. Тухайлбал, 2025.02.13-ний өдрөөс Хаврын чуулган эхлэх хүртэлх хугацаанд тойргийн иргэдийн санал хүсэлтийг сонсон, тус дүүргийн 1-25 хорооны ... иргэдтэй уулзав. Мөн тойрогт эхлүүлсэн ажлуудын явц, хэрэгжилт, тулгамдсан асуудалтай газар дээр нь танилцаж, гарц шийдлийг нь олж, шийдвэрлэн ажиллав. ■

Биокомбинатад 5.9 тэрбум төгрөгөөр **үерийн далан хийгдэнэ**



ХУД-ийн 12 дугаар хороо Биокомбинатын орчимд Туул гол хальж иргэд үерийн усанд автдаг эрсдэлтэй нөхцөл байдалд байсан. Тодруулбал, Биокомбинат орчмын эрсдэлтэй бүсэд 100 орчим айл өрх, амралт сувиллын газрын 500 гаруй иргэн байдаг бөгөөд 47 өрх, амралтын газрын нийт 192 иргэнийг 2024 онд нүүлгэн шилжүүлээд байсан билээ. Тэгвэл энэ асуудал шийдэгдэж Биокомбинатад 5,9 тэрбумын хөрөнгө оруулалтаар үерийн далан хийгдэх юм.



Нисэхийн 10 дугаар хорооны ӨЭМТ-ийн барилгын ажилтай танилцлаа

ХУД-ийн 10 дугаар хорооны хүн ам өсөн нэмэгдэж, өрхийн эрүүл мэндийн төвийн тусламж үйлчилгээнд саатал учирсан юм. Азийн хөгжлийн банк, Дэлхийн банкны санхүүжилт авах чиглэлд ажил явсан ч газрын хэмжээ нь багадсан гэх шалтгаанаар санхүүжүүлэхээс татгалзсан байдаг. Улмаар Ж.Алдаржавхлан засаг даргаар ажиллаж байх хугацаандаа 10 дугаар хорооны нутаг дэвсгэрт зөвшөөрөлгүй баригдсан 23 грашийг буулган газрыг чөлөөлж, 2024 онд дүүргийн төсвийн 1,9 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар барилгын ажлыг эхлүүлсэн юм.

УИХ-ын гишүүн Ж.Алдаржавхлан:

Энэхүү Өрхийн эрүүл мэндийн төв ашиглалтад орсноор өндөр настан, хүүхэд залуус гэрийнхээ хажуунаас эмнэлгийн тусламж үйлчилгээ авах боломж бүрдэнэ.

“Солонго 1,2” хороололд сургууль, цэцэрлэгийн асуудлыг шийдүүлээ

ХУД-ийн 21-р хороонд баригдаж буй 5000 айл, 20 мянга орчим оршин суугчидтай хотхон энэ онд ашиглалтад орно. Гэтэл энэхүү хороололд нэг ч сургууль, цэцэрлэг төлөвлөөгүй байсан. Энэ асуудлыг шийдвэрлэхээр Ж.Алдаржавхлан гишүүн Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдад удаа дараа танилцуулж, тус хотхонд улсын сургууль барих газар болон хотхоны 1-р давхруудад цэцэрлэгийн байр, хотхон хорооллын орц гарцын асуудлыг тус тус шийдвэрлүүлэв.



УИХ-ын гишүүн Ж.Алдаржавхлан:

Өнөөдрийн байдлаар Кинг таувер хотхон 3 мянга орчим айлтай. Энэ хотхонд хоёр ч сургууль байх ёстой атал өнөөдөр нэг ч сургуульгүй байшингаа бариад явж байгаа. Миний өргөн барьж батлуулсан Хот байгуулалтын тухай хуулиар цаашдаа дахиж сургуульгүй хотхон, хороолол төлөвлөхийг хориглолчоож байгаа. Нэг ёсондоо, энэ мэт гаж үзэгдэл дахин гарахгүйн дээр араас нь энэ мэтээр хөөцөлдөөд явах бус анхнаас нь төлөвлөөд явдаг болно.

ХАМГИЙН САЙН СУРГУУЛЬ БОЛ ГЭРТ ОЙРХОН СУРГУУЛЬ ГЭЖ БИ БОДДОГ

Гэрт ойрхон сургууль, цэцэрлэг байх нь аюулгүй байдлаас авхуулаад цаг зав хэмнэх, түгжрэл буурах, өрхийн санхүүд ч нөлөөлөх зэрэг дурдаад байвал олон талын ач холбогдолтой. Тодруулбал,

- **2025 онд** ХУД-т шинээр 4 бага сургууль, цэцэрлэгийн цогцолбор, 6 цэцэрлэг, 3 сургуулийн барилга баригдав.
- **2026 онд** ХУД-т нийт 15 сургууль, 8 цэцэрлэг, 3 бага сургууль цэцэрлэгийн цогцолбор ашиглалтад орно.



1. Сургуулийн өргөтгөл,
640 суудал /2-р хороо/



2. Сургуулийн барилга,
640 суудал /8-р хороо/



3. Сургуулийн барилга,
640 суудал /16-р хороо/



4. Бага сургууль, цэцэрлэгийн цогцолбор /24-р хороо/



5. Бага сургууль, цэцэрлэгийн цогцолбор /16-р хороо/



6. Бага сургууль, цэцэрлэгийн цогцолбор /12-р хороо/



7. Бага сургууль, цэцэрлэгийн цогцолбор /14-р хороо/



8. Хүүхдийн цэцэрлэг,
240 ортой /1-р хороо/



9. Хүүхдийн цэцэрлэг,
200 ортой /15-р хороо/



10. Цэцэрлэгийн өргөтгөл
/5-р хороо/



11. Цэцэрлэгийн өргөтгөл
/1-р хороо/



12. Хүүхдийн цэцэрлэг,
130 ортой /23-р хороо/



13. Хүүхдийн цэцэрлэг,
100 ортой /20-р хороо/

ШАГНАЛ, УРАМШУУЛАЛ



Ерөнхийлөгчийн зарлигаар төрийн дээд одон, медаль гардууллаа

Тулгар төрийн 2234, Их Монгол Улсын 819, Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээн мандуулсны 114, Ардын хувьсгалын 104 жилийн ойг тохиолдуулан Монгол Улсын Ерөнхийлөгчийн 89 дүгээр зарлигаар эрхэлсэн ажил, салбартаа олон жил үр бүтээлтэй ажиллаж онцгой амжилт гарган, эх орныхоо хөгжил дэвшилд үнэтэй хувь нэмэр оруулж буй иргэдэд төрийн дээд одон медаль гардууллаа. ■

Хан-Уул дүүрэг үүсэн байгуулагдсаны түүхт 60 жилийн ойн баярын хуралд мэндчилгээ дэвшүүлж, шагнал гардууллаа



Хан-Уул дүүрэг нь БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1965 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн 79 дүгээр зарлигаар "Ажилчны район" нэртэйгээр байгуулагдсан бөгөөд нийслэлийн ууган дөрвөн дүүргийн нэг юм. Түүхт 60 жилийн ойг тохиолдуулан МУ-ын Ерөнхийлөгчийн зарлигаар дүүргийн хөгжил дэвшилд үнэтэй хувь нэмэр оруулсан иргэдийг төрийн дээд одон медалиар шагнаж, Хан-Уул дүүрэг нийслэлийн "ХАНГАРЬД" одонгоор шагнагдав. ■



Түүхт 60 жилийн ойд зориулсан хүчит бөхийн барилдаанд Улсын заан С.Сүхбат түрүүлж, шагнал гардууллаа

Хан-Уул дүүргийн түүхт 60 жилийн ойд зориулсан "БОГДХАН УУЛЫН ХИШИГ" улс, аймгийн цолтой хүчит 256 бөхийн барилдаанд Монгол Улсын Заан С.Сүхбат түрүүлж, Монгол Улсын Заан Б.Бат-Өлзий үзүүрлэж, шөвгийн дөрөвт Аймгийн Арслан Б.Шаравдорж, Аймгийн Арслан Э.Бат-Эрдэнэ тус тус шалгарлаа. Түрүү, үзүүр, шөвгийн дөрвөн бөхийн шагналыг УИХ-ын гишүүн Ж.Алдаржавхлан гардуулж, амжилт хүслээ. ■






МОНГОЛ УЛСЫН
БАЙНГЫН АЖИЛЛАГААТАЙ ПАРЛАМЕНТЫН ТҮҮХЭН ДЭХ
ЕС ДЭХ УЛСЫН ИХ ХУРАЛ



УИХ-ЫН ГИШҮҮН Ж.АЛДАРЖАВХЛАНГИЙН
ДЭЛГЭРЭНГҮЙ МЭДЭЭЛЭЛТЭЙ ТАНИЛЦАНА УУ

 aldarjavkhlan@parliament.mn

 Алдаржавхлан Жуковын